

**ЖИЖИГ ДҮР, ТОМ ТАЙЗ БА ТОМ ДҮР:
ЛУВСАНШУНУ ХИЙГЭЭД ХVШ ЗУУНЫ ЕВРОАЗИЙН
ОЙРАД ХААНТ УЛС БОЛОН ЧИН УЛСЫН ХАРИЛЦАА¹**

Б. ОЮУНБИЛИГ

Товч агуулга: Лувсаншуну бол Зүүнгарын хаан Цэвээнравдангийн хүү, түүний эх Торгуудын Аюук ханы охин Сэтэржав. Дотоодын ширүүн дайны улмаас Лувсаншуну Торгууд руу очиж, Сэтэржав Цэвээнравдангийн ахмад хөвгүүн Галданцэрэнд шахагдав. Энэхүү төвөгтэй түүхэн нөхцлийн доор Лувсаншуну нэг талаар Торгууд хант улсын хамгааллыг олж, нөгөө талаар Зүүнгар улс түүнээс эмээсний зэрэгцээ Чин улсад чухалчлагдах болов. Найралт төв хаан Торгууд руу элч илгээж, Лувсаншунуг Бээжинд авч ирэн, Галданцэрэнтэй тэмцэлдүүлэхийг хүсчээ. Олон хэлний сурвалжид Лувсаншунугийн хэргийг тэмдэглэснийг ашиглан, тус өгүүлэлд ХVШ зууны Торгууд, Зүүнгар болон Чин улсын хоорондын гадаад харилцаа хийгээд байлдах бодлогын зохиомжийг шинжилнэ.

Түлхүүр үг: Лувсаншуну, Зүүнгар улс, Торгууд хаант улс, Галданцэрэн, Чин улсын баруун умардыг байлдах бодлого

Лувсаншуну нь Зүүнгар улсын хоёрдугаар удирдагч Цэвээнравдангийн бага хатны хүү, түүний эх Ижил мөрний сав газрын Торгууд хант улсын ноёрхогч Аюук ханы охин Сэтэржав. 1725 онд Лувсаншунугийн Хасагтай хамтран Зүүнгараас урвах хэрэг илчлэгдсэний дараа Торгууд руу дутаав. 1727 онд Сэтэржав Цэвээнравданг хордуулан алснаар, Сэтэржав болон түүний хүүхдүүд Цэвээнравдангийн ахмад хөвгүүн Галданцэрэнд цаазаар авахуулагджээ. Лувсаншуну Торгууд хаант улсын хамгаалал, Зүүнгар улсын сэрэмжийг хүртсэний зэрэгцээ Найралт төв хаанд чухалчлагдав. Найралт төв хаан тусгай элчийг Торгууд руу илгээн, Лувсаншунугийн дэмжлэгийг олох, тэр ч байтугай түүнийг

¹ Энэхүү өгүүлэл нь 乌云毕力格, 小人物、大舞台与大角色: 罗布藏舒努和十八世纪欧亚卫拉特汗国与清朝关系, 《清史研究》, 2017年11月第4期-д хэвлэгдсэн.

Бээжинд авч ирэн, Галданцэрэнтэй тэмцэх “үнэт бараа” болгохыг эрмэлзсэн байна. Зүүнгар, Торгууд ойрадын хоёр хаант улс зөрчилдөн сөргөлдөж, Чин улс Евразийн тал нутгийн баруун хэсгийн Торгууд, Хасаг зэрэг холын улсуудтай холбоолон Зүүнгарын хүчийг устгахыг хүссэн нь Лувсаншуну түүхийн тавцан дээр гарч ирэх улс төрийн нөхцөл болжээ.

Энэхүү төвөгтэй нөхцөл нүсэр том тайзан дээр Лувсаншуну хэмээх энгийн бөгөөд нэрд гараагүй жижиг дүр тухайн үеийн түүхэнд нүд гялбамаар гэрэл тусгаж, адилгүй нөлөө, адилгүй өнцгөөс түүнийг чухалчлан үзсэн нь хожмын түүхэнд Ойрад монголын баатрын дүрийг үүсгэжээ. Лувсаншунугийн хэргийг судлах нь XVIII зууны Евразийн тал нутгийн Торгууд хаант улс болон Зүүнгар улсын харилцаа хийгээд Чин улсын баруун умардыг байлдах бодлогыг судлахад маш сонирхолтой юм.

1. Лувсаншуну уг хүн

Зүүнгар улсыг үндэслэгч Галданд V Далай ламаас “Данзан бошогт хаан” (Шашныг баригч хутагт хаан) цол олгов. Хоёрдугаар удирдагч Цэвээнравдан нь Галдангийн төрсөн ах Сэнгийн хүү, “Зоригт эрдэнэ хунтайж” цол хүртэв. Лувсаншуну бол Цэвээнравдангийн хоёрдугаар хөвгүүн юм.

Тод бичгийн сурвалжид “*Цэвээнравдан хоёр хатантай, их хатан Төвөдийн Хошууд хааны ордны Далай хан (Гүүш хан)-ы охин, Лазан ханы эгч Гунгаравдан, хоёр хүүхэд төрүүлсний ахмад нь Галданцэрэн, цол “Дээд ноён”, хоёрдугаар нь “Ноён хамба”, нэр Лувсанпунцаг; хоёрдугаар хатан Сэтэржав нь Шуну зэрэг долоон хүүхэдтэй*”² хэмээсэн байдаг. Оросын их бууны цэргийн ахмад И.Унковский Зүүнгарт очин, Цэвээнравдантай биечлэн уулзаж, зүүнгарын дотоод хэрэгтэй танилцжээ. Түүний хэлснийг үндэслэвэл “1724 оны үед Цэвээнравдан 60 нас дөхөв, нэгдүгээр эхнэрийн нэр Гунгаравдангаас Галданцэрэн төрөв, 1723 онд нас барав; хоёрдугаар эхнэрээс Шунудамба, Шуну хашиха, Балиг (Баханга) болон өөр нэгэн Балиг төрөв. Чизанга, Ноён хашиха, Борон (Баран) охидтой”³ гэжээ. Паласын тэмдэглэлд “*Цэвээнравдан таван хүү, таван охинтой, нэгдүгээр хатнаас Галданцэрэн болон Лувсаншуну төрөв, хоёрдугаар хатнаас (Сэтэржав) Лувсанхашиха, Эрх Баран болон Эрхда Баран гурав төрсөн бөгөөд гурвуул чацуу.*

² *Богд Чингисийн төрийг бариад хаан үүрэг тэтгэсэн түүх (тод үсэг)* //Бадаа, Алтаншаа, Эрдэнэ эмхэтгэн тайлбарлав. *Ойрад соёлын дээж*, Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1992, Тал 12-13.

³ Унковский, И. *XVIII зуунд их бууны цэргийн ахмад Шинжаанд үзэж сонссон тэмдэглэл*, Орчуулсан Сун Сиши, Хармөрний боловсролын хэвлэлийн хороо, 1999, Тал-211.// 伊。温科夫斯基著, 尼。维谢洛夫斯基编《十八世纪炮兵大卫新疆见闻录》, 宋嗣喜译, 黑龙江教育出版社。

*Цэрэн, Жамав, Чучу дөрвөн охинтой*⁴ хэмээв. “Баруун орны адил үсэгт ойллого”-д “Цэвээнравдан таван хүүхэдтэй. Галданцэрэн (төвөдөөр “*dga'ldan tshe ring*”, модоор “*galдан cering*”), Шунудамба (төвөдөөр “*gzhun nu bstan pa*”, модоор “*ᠰᠢᠨᠤᠳᠠᠮᠪᠠ*”), Лувсаншуну (төвөдөөр “*blo bzang gzhun nu*”, модоор “*lobzang ᠰᠢᠨᠤ*”), Баран (модоор *bārang*), Бага Баран (модоор *bayabārang*)” хэмээжээ. Галданцэрэнгийн дэргэд байсан нэгэн дөрвөд тайж, Сэтэржаваас дөрвөн хүү, дөрвөн охин төрсөн хэмээсэн ч зөвхөн Лувсаншуну, Их Бараныг нэрлэв. Өөр нэгэн Зүүнгарын элчийн уламжилсан хятад сурвалжид, Цэвээнравданы “гуравдугаар эхнэр Эмчин”-ийг дурдсан ч, төрүүлсэн хүүхдийн тухай мэдээ байхгүй. Манж сурвалжид Лувсаншунугийн эх өөр дүү Цэвээн, Их Баран, Бага Бараны тухай тэмдэглэл бий. Нэгтгэн үзвэл, Цэвээнравдан багадаа гурван эхнэртэй, авааль гэргий нь Хошууд хааны охин Гунгаравданаас Галданцэрэн, Лувсанпунцаг төрсөн, удаах Хамба лам нас барсан учир ихэнхдээ угийн бичигт тэмдэглээгүй; хоёрдугаар эхнэр Торгууд хааны охин Сэтэржаваас Лувсаншуну, Шунудамба, Их Баран, Бага Баран дөрвөн хүү, дөрвөн охин төржээ. Дөрвөн охидоос том охины нэр манжаар “*cedzung*”, хятадаар Чизан (奇赞格), германаар “*tshisang*” хэмээн адилавар, бусад охидын нэрс нэлээд зөрүүтэйгээр тэмдэглэгдсэн байна. Гуравдугаар эхнэр Эмчиний биеийн гарал нь тодорхойгүй, хүүхэд төрөөгүй бололтой.

Лувсаншунугийн нэрийг олон хэлний сурвалжуудад өөр өөрөөр бичдэг. Тод бичгийн сурвалжид Шуну, Шуна, Шунай, Лувсансуну, Суну; хятад сурвалжид 罗布藏舒努, 罗卜藏舒努, 罗布藏舒诺, 罗布藏硕努, 罗卜绰诺 зэргээр тэмдэглэсэн байдаг. Унковскийгийн тайланд “Шунудаваа” хэмээсэн нь дүү Шунудамбын нэртэй хутгасан бололтой. “Баруун орны адил үсэгт ойллого”-д таван төрлийн үсэг ашиглан Лувсаншунугийн нэрийг тэмдэглэсэн бөгөөд төвөдөөр “*blo bzang gzhun nu*” хэмээсэн нь “Энэрэнгүй сэцэн залуу” гэх утгатай. Бичлэгийг дөхөм байлгахын тулд онцгой тохиолдлоос бусад үед “Шуну” хэмээн бичлээ.

Шунугийн төрсөн оны тухай нарийн тэмдэглэл байхгүй. “Умрын говийг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг”-т тэмдэглэсэн нь: Энх-Амгалангийн гучин тавдугаар (1696) оны 7-р сард, Галдангийн дэргэдэх хүн Дамба хашиха нар “Галдан хэрэв орговол торгуудад очихгүй, учир нь зам хол бөгөөд Аюукын охин Цэвээнравдантай ураг барилдсан”⁵-ыг задруулжээ. Иймд Сэтэржав оройтлоо

⁴ Палас, П. С. *Дотоод хуурай Ази тивийн Өөлдийн түүхийн материал*, Орчуулсан Шао Жиэндун, Лиу Иншөн. Юннан их сургуулийн хэвлэлийн хороо., 2002. Тал-44. // P.S. 帕拉斯《内陆亚洲厄鲁特历史资料》邵建东, 刘迎胜译, 云南大学出版社。

⁵ *Биеэр дайлж Умарын говийг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг*, жинхэнэ зохиол, дэвтэр 27; *Чингийн Шэнзугийн магад хууль*, дэвтэр 174, Энх-Амгалангийн 35-р оны 7-р сарын шар морь өдөр.

гэхэд 1695 оны сүүлчээр Цэвээнравдантай гэрлэсэн. Руо Сункуаны судласнаар Шунугийн ах Галданцэрэн 1695 онд төржээ⁶. Жао Вэйбинь дээрх хоёр баримтыг үндэслэн Шуну 1696-1697 онд төрсөн⁷ хэмээснийг зохиогч илүү итгэмжтэй хэмээн үзэж байна.

Оросын Цэргийн явдлын хүрээлэн Чин улсын ГМТЗЯЯ-нд өгсөн мэдэгдэл⁸ болон Паласын тэмдэглэснээс⁹ үзвэл Шуну 1732 онд нас баржээ. Златкин Оросын Гадаад бодлогын архивын Халимагийн дансны 1735 оны данс-1, эвхмэл 69-өөс эш татан тэмдэглэхдээ, 1735 оны 7-р сард Оросын эрх баригчид Оросын гадаад хэргийн танхимтай хэлэлцээр хийхээр ирсэн Зүүнгарын элчид: “*Шуну аль эрт нас барав, үхсэний дараа хүүхдүүдээс нь нэг ч үлдээгүй. Харин эхнэр нь Оросын харьяат учир та нарт буцааж өгөх нь зохимжгүй*”¹⁰ (Шунугийн эхнэр оросын харьяат гэдэг нь Шуну Торгуудад очсоны дараа Дондов омбугийн охиныг богтлон авсныг зааж байна) хэмээн албан ёсоор мэдэгджээ. Зохиогч үзэхдээ, Златкины эш татсан уг мэдээ нь Шунуг 1735 онд нас барсныг баталж чадахгүй, энэ нь Оросын тал Зүүнгарын элчид Шунуг хэдийнээ нас барсныг мэдэгдсэн он, иймд уг баримт нь Шуну 1735 оны үед хэдийнээ нас барсныг гэрчилнэ. Дээр дурдсан сурвалжтай холбогдуулан зарим судлаачид Шунуг 1732 онд нас барсан хэмээн үздэг.

Цэвээнравдангийн бие Төвөдийн Хошууд хаан хийгээд Ижил мөрний Торгууд хаантай ураг барилдахын зэрэгцээ өөрийн охидыг хөвгүүдтэй нь ураглуулжээ. Гэвч, Цэвээнравдан Торгууд болон Хошууд хааны гэр бүлд сайн санаа агуулсангүй, Зүүнгарт ашиг олохын тулд Хошууд хаантай байгуулсан ургийн харилцааг ашиглан Лазан ханыг мэхэлж цэрэг хөдөлгөн ороод, 1717 онд Хошууд хааны ордныг устгаж, хэсэг хугацаанд Төвөдийг эрхшээсэн билээ. Үүний адил Зүүнгарын Евразийн тал нутаг дахь ашиг сонирхлын тулд Цэвээнравдан Аюук хантай өө эвдэрснээр хоёр талын харилцаа хурцдав. Цэвээнравдан нас ахих үед залгамжлагчийн асуудал гарч ирснээр Сэтэржав бага хатан боловч Аюук

⁶ Руо Сункуан. Цэвээнравданы мандалт. “*Чин улсын Монголын түүх ба шашин*”. Хармөрний боловсролын хэвлэлийн хороо, 1994, Тал-79. // 若松宽《策妄阿喇布坦的崛起》，见氏著《清代蒙古的历史与宗教》，黑龙江教育出版社。

⁷ Жао Вэйбинь. *Хасаг ба Зүүнгарын улс төрийн харилцааны түүхийг судлах нь: 1680-1745*, Шинжааны багшийн их сургуулийн магистрын өгүүлэл. 2010. Тал-19. // 赵卫宾《哈萨克与准噶尔政治关系史研究：1680-1745》，新疆师范大学硕士论文。

⁸ Николай Бантыш Каменский. *Орос Хятад хоёр улсын гадаад харилцааны сурвалжийн эмхэтгэл*, Хятадын Ардын их сургуулийн Орос хэл заан судлах танхимаас орчуулав. Худалдааны явдлын хэвлэх газар., 1982. Тал-235. // 尼古拉·班帝什·卡姆斯基编著《俄中两国外交文献汇编》中国人民大学俄语教研室译，商务印书馆。

⁹ Палас, П.С. *Дотоод хуурай Ази тивийн Өөлдийн түүхийн материал*, 2002. Тал-44.

¹⁰ Златкин, И.Я. *Зүүнгар хаант улсын түүх*, Орчуулсан Ма Манли (马曼丽). Ланжөү их сургуулийн хэвлэлийн хороо., 2013. Тал-272.

ханы охин хэмээн авирлаж, авааль эхнэрийн ахмад хөвгүүн Галданцэрэнгийн байр суурийг зөвшөөрөлгүй, Цэвээнравданд туйлаар дургүйцэн, өөрийн хүүгээ түшиж, Зүүнгарын төрийн эрхийг булаах санаа агуулснаар өөрөө болон хүүхдүүд нь эмгэнэлт явдлаар дуусчээ.

2. “Шунугийн хэрэг”

1725 онд Цэвээнравдан гэнэт хоёрдугаар хүү Шунуг баривчлах зарлиг буулгасанд, урьдчилан мэдээ хүргэснээр Шуну амьд үлдэн, эцэстээ Ижил мөрөн дэх Торгууд руу дутаан очив. Удалгүй Цэвээнравдан гэнэт нас баран, Галданцэрэн хаан ширээнд сууж, Шунугийн эх, дүү нарыг хүйс тэмтрэн алжээ. Энэ хэргийг уг өгүүлэлд “Шунугийн хэрэг” хэмээн нэрлэж байна. Тэгвэл “Шунугийн хэрэг” гэж чухам ямар хэрэг вэ?¹¹

Найралт төвийн тавдугаар (1727) оны 7-р сарын шинийн 5-нд, Галданцэрэн “энэ жил миний эцэг гэнэт нас барав”¹² хэмээн албан ёсоор мэдэгдэн, Төвөдөд хүн илгээж эцгийн тул гүрэм хийлгэх зөвшөөрлийг Чин улсаас хүсжээ. Галданцэрэн “гэнэт нас барав” хэмээх үгээр эцгийн нас барсан шалтгааныг тайлбарласангүй. Гэвч хэрэг дээрээ Цэвээнравдангийн элч аль хэдийн “Шунугийн хэрэг”-ийг мэдэгдсэн болох нь сурвалжаас тодорхой харагдана. Санамсаргүй болгох нь Чин

¹¹ Лувсаншунугийн хэргийн тухай өмнөх хүмүүс анхаарсан ч үр дүнг нэгтгэсэн нь бага. Өмнөх хүмүүсийн судалгаа нь И.Я.Златкины “Зүүнгар хаант улсын түүх”-ийн агуулгатай (тал 269-272) холбогдоно. Златкин Оросын Гадаад бодлогын архивт нуусан Халимагийн дансан дахь Шуну болон Цэвээнравдан нууцаар алагдсан хэрэгтэй холбоотой нарийн мэдээг уншигчдад өгсний зэрэгцээ Галданцэрэн-Лувсаншунугийн Зүүнгарын ноёрхох эрх мэдлийн төлөөх дайныг энгийнээр хүүрнэсэн байдаг. Хятад улсад Шунугийн хэргийг ойрын жилүүдээс судалжээ. 2012 онд Цай Жиа И-гийн нийтэлсэн “Лувсаншунугийн нэг насны үйл хэргийг эмхэтгэн шинжлэх нь”-д Лувсаншуну уг хүн, түүний хэргийг харьцангуй бүрнээр шинжлэн хүүрнэв. 2013 онд Хятадын Төвийн Үндэстний Их Сургуулийн Лиу Жин (刘锦)-ий докторын өгүүлэл “Чин улсын Найралт төв хааны баруун умардын төрийн бодлогыг судлах нь” (《清代雍正朝的西北政策研究》)-ийн тусгай нэг хэсэг “Лувсаншуну- Зүүнгар шинэ сүрдүүлгийн урьдчилан сэргийлэлт” (《罗布藏舒努与准噶尔新威胁之预防》), тал 144-150, Лувсаншунугийн хэрэг үүссэний дараа Найралт төв, их жанжин Юе Жунчи нар Лувсаншунугаар торгууд, хасагийн цэргийг удирдуулан ирүүлж, Зүүнгарыг эрхшээх аргыг зохицуулах тухай хэрхэн ярилцсаныг голлон хөндөв. 2015 оны Хятадын Ардын Их Сургуулийн Ван Си (王曦)-гийн докторын өгүүлэл “Галданцэрэний эрхшээлийн үеийн (1727-1740) Зүүнгар-Чин улсын дайн хийгээд найрамдлыг судлах нь” (《噶尔丹策零统治时期(1727-1740)准噶尔与清朝的战争与议和的研究》)-д Хотон нуурын дайны өмнөх Зүүнгарын байдлыг хэлэлцэхийн зэрэгцээ Лувсаншунугийн хэргийг дурдав. Ван Си Цэргийн тухайн газрын манж хэлээр тэмдэглэсэн нэмэлт баримтыг тайлан уншсанаар Цэвээнравдан нууцаар алагдсан хэргийг судлах материалаар хангаж өгөв. Дээрх өгүүлэл дотроос Цай Жя И тусгайлан Лувсаншунугийн нэг насны амьдралыг судалсан боловч Лувсаншуну болон Цэвээнравданы харилцаа, Лувсаншуну Торгууд руу очсон шалтгаан, цаг хугацаа, төрсөн, нас барсан он зэрэгт зөвлүүштэй зүйл нэлээд байна.

¹² Найралт төвийн манж улаан цохолборт айлтгалын бичгийн бүрэн орчуулга (доод). Хуаншан номын хороо, 1986, тал-1480. // 《雍正朝满文朱批奏折全译》(下), 黄山书社.

улсын дайснаа гутаах нэгэн арга бөгөөд “Чин улсын магад хууль” зэрэг албан түүхэнд, Галданцэрэн хойд эхээ алсан хийгээд Шуну Торгууд руу дутаан очсон, Чин улс туйлаар анхаарч байсныг тэмдэглээгүй байдаг¹³. Иймд албан түүхээс Найралт төвийн тавдугаар онд Зүүнгарт үүссэн эдгээр хэрэг явдлын үнэн байдлыг харж чадахгүй. Гэвч манж, хятад, орос хэлний архивын мэдээнээс “Шунугийн хэрэг”-ийн тухай төрөл бүрийн тэмдэглэлийг олж харна.

Ордны дансны манж хэлний улаан цохолборт хуудсанд, Найралт төвийн зургаадугаар (1728) оны цагаан сарын 29-ний өдөр, Цэргийн жанжин Басай Галданцэрэнгийн элч Тэлэйгийн өгүүлснийг айлтгасан нь: *“Лувсаншуну торгуудаа очоод эхнэр авч, торгуудаас хортой эм өгүүлэн, Галданцэрэнг хорлон алахаар Шунудаваа, Их Баран, Бага Баранг илгээсэн ч тэдний санаа бүтэлгүйтэн, хоруулган Цэвээнравданг хөнөөв. Галданцэрэн энэ хэргийг тодруулан, Цэвээнравдангийн ойрын бараа бологч Бажижийн толгойг авч, Шунудаваа, Их Баран, Бага Бараны нүдийг сохлон зооринд хорив”*¹⁴ гэжээ.

Ордны дансны Найралт төвийн хятад хэлний улаан цохолборт хуудсанд, Найралт төвийн зургаадугаар (1728) оны 3-р сард, Хан жөугийн зүүн жигүүрийн мэйрэний занги Жантай айлтгасан нь: *“Өнөөдөр Найралт төвийн зургаадугаар оны 3-р сарын шинийн наймны өдөр, Ван Зифу нууцаар мэдүүлснээс харахад харь элч нарын дотор Аржсаа, Мэндэв хоёр хүн амаар хэлснийг үзвэл Цэвээнравдангийн өвчнөөр нас барсан шалтгаан нь, өнгөрсөн жил таван сарын шинийн есөнд Цэвээнравдан хоёрдугаар хатан Сэтэржавын гэрт архи ууж, гуравдугаар хатан Эмчиний гэрт очив. Гэнэт хэвлий өвдөж зарлигаар эмч ламд үзүүлэв. Лам үзсэний дараа хэлсэн нь: Хунтайж хаан ямар зүйл идэв? Цэвээнравдан хэлсэн нь: Сэтэржавын гэрт архи уув. Лам хэлсэн нь: Хунтайж хордсон байна хэмээв. Цэвээнравдан бачимдаж Галданцэрэнг яаран дуудаж зарлиг буулгав: Би нэг насаараа сайн эр явав, өнөөдөр торгууд хатан Сэтэржавын гэрт үхлээ. Намайг үхсэний дараа чи Харбалт газарт бүү нутаглах, Илийн газар буцан нүү, тэнгэрийн улсын хаанд хүн илгээж нигүүлсэл хүсч хамгаалуул. Чи хэрэв миний үгийг сонсохгүй бол гарцаагүй торгуудын Аюукын хорыг хүртэнэ гэв. Зарлиг буулгасны дараа хоромхон зуур нас барав. Манай бага тайж Галданцэрэн зарлигийн дагуу зүүнгар олны тэргүүн болж Сэтэржавыг авч ирээд, хунтайжийг хорлосон учрыг асуув.*

¹³ “Чин улсын магад хууль” зэрэг албан бичиг нь хааны гавьяа зүтгэлийг магтан дуулах үүрэгтэй. Найралт төв хаан Лувсаншунуг татахын тулд мэрийсэн боловч өчүүхэн ч амжилт ололгүй бүрэн ялагдлаар дууссан учир Чин улсын албан түүхийн сурвалжид энэ хэргийг дурдаагүй.

¹⁴ *Найралт төвийн манж улаан цохолборт айлтгалын бичгийн бүрэн орчуулга (доод)*, Хуаншан номын хороо, 1986, тал-1600.

Сэтэржав хэлэхдээ: “Учир нь хунтайж ахмад хөвгүүн Галданцэрэнг сайнаар үзэн, миний хүүхдүүдийг бүгдийг бие даалгахгүй. Би бол торгуудын Аюукын охин, надаас төрсөн хүүхэд Галданцэрэнг гүйцэхгүй, иймээс хорттой архиар хунтайжийг хорлов” хэмээв. Ярьж дуусаад ардууд Сэтэржавыг хутгаар цавчин алж, агшин зуур үхэв. Манай бага тайж Сэтэржавын үлдсэн хүүхдүүдийг бүгдийг сахиулаад, бага тайжтай адил олон тэргүүлэгчтэй зөвлөлдөн, торгуудын Аюук охиныхоо өшөө авахаас эмээж, хааны мэндийг асуун, алба барьж, хамгааллыг хүсэн элч илгээсэн нь ийм учир”¹⁵ хэмээжээ. Эдгээр нь Зүүнгарын элч нарын авч ирсэн мэдээлэл. Үүнийг үндэслэвэл, Сэтэржав архинд хор хийж Цэвээнравданг хорлон алсан байна. Хор хийх шалтгаан нь Цэвээнравдан түүний ахмад хөвгүүн Галданцэрэнд сайн, Сэтэржаваас төрсөн хүүхдүүдийг чухлаар үзээгүйд оршжээ.

Цэргийн тухайн газрын манж хэлний сурвалжид, Найралт төвийн зургаадугаар (1728) оны 3-р сарын шинийн 3-ны өдөр, Мэйрэний занги Гэмэл зүүнгарын оргодол Пунцагийн яриаг мэдүүлсэн нь, *“Лувсаниуну Хасаг руу дайлан ороход гурван мянган цэргийг авч орсон билээ. Очоод зургаан жил болов. Лувсаниуну хасагийг тэргүүлсэн ардын хамт толгойн оройд бурхан тавиад үй зайгүй дотно болсугай хэмээн андгайлав. Энэ үгийг Цэвээнравдан сонсоод толгойн оройд бурхан тавиад хасагтай андгайлваас энэ ямар санаатай хэмээгээд даруй Цагаан хашихаг зарж Лувсаниунуг баривчлахаар явуулав. Баатар зайсан, тайж Жал, Нэмэх гурван хүн сонсоод Лувсаниунуд очиж “Цагаан хашихаг зарж, баривчилуулахаар ирэв” хэмээн хэлсэнд, Лувсаниуну цэргийн хүрээний дотроос долоон хүнийг авч, нум сумыг зүүгээд цэргийн хүрээнээс хөдөлж, торгуудыг яаран зорив. Дараа жил нь түүний нагац аав Аюукын газарт хурч, түүний эх Сэтэржав эгч Цэзэн, дүү Их Баран, Бага Баран дөрөвт хорттой эм өгүүлэн, түүний эцэг Цэвээнравданг хорлон ал хэмээн захив. Тэр үед Цэвээнравданы бие маш хүнд байв, түүний бага эхнэр Сэтэржав, том охин Цэзэн, хүү Их Баран нар архинд хор хийж, Цэвээнравданг мэхлэн хоол шингээхэд тустай хэмээн уулгаж, тэр даруй хордуулан алав. Дөрвөн хүн бас зөвлөлдөж, Галданцэрэнд хүн илгээн, түүний эцгийн өвчин хүндрэв хэмээн хэлүүлэе, энэ лав ирнэ, ирсний дараа бид хутгыг ханцуйнд нууж алая, энэ үхсэний дараа Зүүнгарын хэргийг бид толгой мэдэж чадна хэмээн зөвлөлдөн тогтоод, Их Баран хутгыг ханцуйнд нуув. Галданцэрэн түүний эцгийн өвчин хүндийг сонсоод даруй ирэв. Цагаан зайсан энэ хэргийг мэдээд түргэлэн Галданцэрэнг угтан хэлж, “Их Баран ханцуйнд хутга нууж*

¹⁵ Ордны улаан цохолборт нутагбар. Дансны дугаар 04-01-30-378v1. Хятадын Түүхийн нэгдүгээр архив. // “宫中档朱批奏折”, 档案号04-01-30-378v1, 中国第一历史档案馆藏缩微胶卷。

чамайг алсугай хэмээмүй, чи битгий ор, хурдан буцах, эх хүүхэд дөрөв зөвлөлдөөд таны эцэг хүүг алж, Зүүнгарын хэргийг хамаарсугай хэмээмүй” хэмээв. Тэгээд Галданцэрэн даруйхан Цагаан хашихагийн хамт буцаад, гуравдугаар өдөрт цэргээ авч, түүний хойд эх Сэтэржав, түүний наалдан явалдсан эр Ширмаж энэ хоёрыг баривчилж, нэг газарт нүцгэлэн тэврэлдүүлэн хүлээд, эрийн махыг зорж эмд идүүлэн, эмийн махыг зорж эрд идүүлэн, Галданцэрэнгийн бие үзэн зоруулан алав. Их Бараныг бариад Галданцэрэнгийн үг “чи хутгыг нууж намайг алсугай хэмээв. Одоо энэ хутгаар чиний нүдийг сохолсугай” хэмээгээд Галданцэрэн Их Бараны нүдийг сохлоод Аксу хотод хорив”¹⁶ хэмээжээ. Пунцагийн мэдүүлгээс үзвэл, Шуну Хасагтай хамтран Зүүнгарын эсрэг холбоо байгуулсан учир эцэг нь түүнийг баривчлах гэжээ. Шуну ялаас айн Торгууд руу дутаан очоод, өөрийн эхэд хортой эм өгүүлэн, Цэвээнравданг хордуулан алсан байна. Сэтэржав нар үргэлжлүүлэн Галданцэрэнг алж, Зүүнгарын ноёрхох эрх мэдлийг олж авахаар арга сүвэгчилсэн боловч бүтэлгүйтэж, эсэргээрээ Галданцэрэнд цаазаар авахуулжээ.

Цэргийн тухайн газрын манж хэлний сурвалжид, Тэнгэрийн тэтгэсний анхдугаар (1736) онд, Цэргийн яамны сайд Юньлу Зүүнгарын оргодол дөрвөд тайж Цэрэний мэдүүлгийг айлтгасан нь: “Би Галданцэрэнгийн албат, дөрвөдийн тайж, 25 нас. Намайг 14 настай байхад Лувсаниуну Хасаг руу дайлан орсны дараа Цэвээнравдан Лувсаниунуг урвах гэж байна хэмээгээд хүн илгээж барихад, Лувсаниуну мэдээд Торгуудын газарт очив. 16 настай байхад Цэвээнравданы дөрөвдүгээр хүү Их Бараныг даган төрийн эрдмийг сурав. Цэвээнравдан үхсэний дараа Галданцэрэн түүний эцгийн бага эхнэр Сэтэржавыг, Цэвээнравданыг хорлон алав хэмээн Сэтэржавыг алав. Төрсөн дөрвөн хүү, дөрвөн охины нүдийг сохолж Яркем, Кашгар хотод хориод үхүүлэв. Миний зэрэг даган явсан дөч хүрэх хүнийг алав. Намайг хүүхэд хэмээн хэлтрүүлэв”¹⁷ хэмээжээ. Цэрэн нь нийгмийн байр суурьтай Галданцэрэнгийн албат, байдлыг илүү ойлгох учир итгэмжтэй. Түүний өчил Пунцагийн үгтэй үндсэндээ таарч байна.

Халимагийн архивын дансанд “Шунугийн хэрэг”-тэй холбоотой¹⁸ баримт нэлээд бий. Зүүнгарт очсон оросын элч Д.Ильин 1727 оны 12-р сарын 13-нд

¹⁶ Чин улсын Шинжааны манж архивын эмхэтгэл (нэг). Гуанси багшийн их сургуулийн хэвлэлийн хороо, 2012, Тал 36-38. // 《清代新疆满文档案汇编》 (一), 广西师范大学出版社。

¹⁷ Чин улсын Шинжааны манж архивын эмхэтгэл (дөрөв). 2012, Тал 318-319. Цэрэн 1712 онд төрсөн, 1725 онд 14 (13) настай, 1727 онд 16 (15) настай байсан. Өчил дэх жил нь бодит хэрэг үүссэн хугацаатай таарч байна.

¹⁸ Орос сурвалжийн мэдээ нь Оросын Гадаад бодлогын архивын Зүүнгарын данснаас ирэв //И.Я.Златкин. Зүүнгар хаант улсын түүх. Ланжөү их сургуулийн хэвлэлийн хороо., 2013. Тал 269-270.

Тобольскт ирээд, Галданцэрэн “*Шунугийн эх Сэтэржав болон Аюукын элч нар хуйвалдан Цэвээнравданг хордуулж алсан*” хэмээн үзэж байгаа тухай ярьжээ. Орос сурвалжаас харвал, хэрэг явдлын эхлэл 1723 оноос улбаатай. Тус онд Цэвээнравдан өөрийн охиныг Аюук ханы хүүтэй ураглуулахаар Ижил мөрөн рүү элч илгээсэн байна. 1724 онд Аюук хан Ижил мөрнөөс зайсан Эх абугайг Зүүнгарт илгээн Цэвээнравданы охидыг Аюукын бусад гурван хүүтэй ураглуулахаар зуучлуулжээ. Цэвээнравдан санал нэгтэй байгаагаа илэрхийлэн, охиддоо 100-аас багагүй хүн өгч, 8000 хүнээр хамгаалуулан хүргэхээ мэдэгдсэн байна¹⁹. 1727 онд дахин шинэ элчийг Ижил мөрнөөс Зүүнгар руу явуулсан ба эдгээр элч ирсний дараа Цэвээнравдан гэнэт нас баржээ. Цэвээнравданы ахмад хөвгүүн Галданцэрэн торгуудын дөрвөн элчийг цаазалж, хоёрыг нь цөллөгт явуулан, Эх абугайг шоронд хориод, Сэтэржав болон түүний гурван охиныг тамлан хороосон байна²⁰. Галданцэрэн оросын эх баригчдад хандан “*миний дүү Халимагт очоод Дондов омбутой хамтран миний хойд эх Сэтэржавд хортой эм өгүүлж, намайг хорлон алахыг оролдов. Хойд эх ирж намайг хорлон алахаас эмээн, миний эцэгт мэдэгдэж том зовлон тохиолдохоос айж, миний эцгийг дураар хорлон алахыг зэхэв. Тэр үнэхээр хөнөөж, миний эцгийг дураар хорлон алав*”²¹ хэмээн мэдэгджээ. Дондов омбу нь Аюук ханы хүү Гунжавын хөвгүүн, герман сурвалжаас харвал Шуну Торгуудад очсоны дараа түүний охин Цэрэнбалсанг эхнэр болгон авчээ²².

Дээрх орос сурвалж болон Зүүнгарын элч, оргодлын үг үндсэндээ таарч байна. Гэвч сурвалж дунд адилгүй мэдээлэл ч мөн бий. Жишээ нь, Холхи дахиныг тогтоогч их жанжин Юе Жунчи Зүүнгарын оргодол Болуугийн өчгийг мэдүүлсэн нь: “*Урьд Цэвээнравдан байх үед Галданцэрэн Лувсанишунутай угаас эегүй, байнга Цэвээнравданы өмнө Лувсанишунуг алах аргыг заахыг шална. Цэвээнравдан алахыг зөвшөөрөхгүй, Лувсанишуну бол сайн эр, түүнийг алвал манай хүн бутарна, хуурмаг хөдөлж болохгүй гэж хэлнэ. Хожим Галданцэрэн бас Лувсанишуну урван оргох гэж байна хэмээх үгийг дахин Цэвээнравданы өмнө хэлэв. Цэвээнравдан хэлсэн нь: Тэр нэгэнт ийм болов, чи очиж түүнийг барь хэмээв. Галданцэрэн цэрэг удирдан Лувсанишунуг бүслэн суув. Лувсанишуну яаран нум сумыг авч олонд хэлсэн нь: Би та нарын эзэн биш гэж үү хэмээсэнд, олон энэ үгийг сонсоод замыг нээж түүнийг явуулав. Лувсанишуну долоон хүн дагуулан дайран гарч хасагийн газар луу дутаан очихоор явав. Хожим хасагт Абархайл ханы охиныг богтлон авч бас Абархайл*

¹⁹ Оросын Гадаад бодлогын архив, *Зүүнгарын данс*, 1727-1729, данс [б.н], хуудас 80.

²⁰ Оросын Гадаад бодлогын архив, *Зүүнгарын данс*, 1729, данс 8, хуудас 73.

²¹ Оросын Гадаад бодлогын архив, *Зүүнгарын данс*, 1727-1729, данс [б.н], хуудас 58.

²² Палас, П. С. *Дотоод хуурай Ази тивийн Өөлдийн түүхийн материал*, 2002, Тал-44.

ханы толгойлогч Халдоржийн охиныг Лувсаншунуд эхнэр болгон өгөв. Лувсаншуну дутааснаас хойш Цэвээнравданы өвчин өдрөөс өдөрт хүндэрч удалгүй үхэв. Галданцэрэн зарим яриаг зохион хэлсэн нь: Цэвээнравдан Лувсаншунугийн эхийн авч ирсэн хортой эмэнд хордон үхэв, иймээс Лувсаншунугийн эхийн нүдийг сохолж, хэлийг огтолоод бас биеийг цовдолов. Нэг өдөр цэлмэг тэнгэрт гэнэт нударган мөндөр гаран ирж Галданцэрэний гэрийг эвдэв. Галданцэрэн бас Лувсаншунугийн гурван эрэгтэй, гурван эмэгтэй дүү, нэг дүү нэр Их Бараныг алав, нэг нэр Бага Баран, эмэгтэй дүү Чилжийн нүдийг сохолж газарт нуув, ганц үлдсэн дүү Шунудавааг авч ирсэн эмээр нь нүдийг хорлов. Одоо хотонд сахин хамгаалж байна. Лувсаншунугийн хүү дөнгөж таван настай, нэр Ач баран”²³ хэмээжээ.

Орос сурвалжаас үзвэл, Шуну Торгууд руу дутаасан шалтгаанаа Оросын талд хэлэхдээ: “учир нь тэр эцэг хунтайжийн улсад байх үед улсын бүх цэрэг түүнийг хүндэтгэн, түүнийг эцгийн залгамжлагч болгохыг хүснэ. Хунтайжийн том хүү, Шунугийн эх өөр ах үүнд их атаархаж, тэдний эцэг-хунтайжийг санаатайгаар өдөөн хатгаснаар Шуну эцэгтэйгээ эвдрэлцэж, хунтайж Шунуг алахаар сэтгэл шулуудсан”²⁴ гэжээ. Болуу эцэг хүү нь Лувсаншунугийн харьяат. Шуну хасаг руу дутаасан үед эцэг хүү Зүүнгарт хоцорчээ. Хожим Болуугийн эцэг Хасагийг сахин хамгаалж байхдаа олзлогдон алдаа гаргаснаар Галданцэрэнд алагдаж, тэрбээр Галданцэрэнгээс доромжлолыг хүртжээ. Иймээс Галданцэрэнд өшөөрхөн, Шунуг өмөөрсөн шинж илэрнэ. Шуну өөрийнхөө ял зэмлэлийг бултуулсан тухайд гайхах зүйлгүй, түүний хэлсэнд итгэх хэрэггүй. Дээрх баримтууд нь “Шунугийн хэрэг”-ийн тухай гол мэдээг агуулсан. Жижиг сажиг зүйлс нь зөрөх нь тодорхой, бид тэр дундаас зарим чухал асуудлыг эмхлэн ойлгох шаардлагатай.

Нэгт, Шунугийн дутаан гарсан цаг, шалтгаан. Ойрын жилүүдэд Хятад улсын эрдэмтэд, Галданцэрэн түүний хойд эх үхсэний дараа дотроо гүн гүнзгийгээр хорсож, түүний төрсөн хүүхдүүдийг хүйс тэмтрэн алсан. Шуну цэргээ удирдан гадна сахин хамгаалсныг, харьяатууд нь сонсоод, нэн даруй самуун үүсгэв. Шуну мэдээ сонсоод “маш ихээр айж, даруйхан цөөн тооны дагагсадаа удирдан Хасагийн хил рүү дутаав”. Түүний дутаан гарсан үеийг “хятад сурвалжийн мэдээнээс харвал 1728 (Найралт төвийн зургаадугаар) оны хавар намрын цаг”²⁵ хэмээн зохион

²³ *Найралт төвийн хятад улаан цохолборт айлтгалын бичгийн хэмтгэл*, 18-р боть, Жиансу эртний бичгийн хэвлэлийн хороо, 1991, Тал-891. // 《雍正朝汉文朱批奏折汇编》第18册, 江苏古籍出版社。

²⁴ Оросын Гадаад бодлогын архив, *Зүүнгарын данс*, 1727-1729, данс 16, хуудас 22.

²⁵ Цай Жиа И. Лувсаншунугийн нэг насны үйл хэргийг эмхэтгэн шинжлэх нь. *Баруун монгол өгүүллийн тавцан*, 2012 оны 2-р хугацаа. Тал 7-8. // 蔡家艺:《罗布藏舒努生平事迹辑探》,《西部蒙古论坛》。

бичиж байна. Өмнө эш татсан сурвалжуудыг үндэслэвэл, энэхүү дүгнэлт буруу болох нь тодорхой. Учир нь Шуну дутаан гарсан үе уг хэрэг явдлын шинж чанар болон жижиг сажиг зүйлстэй холбоотой, иймд алхам алхмаар шинжлэн хүүрнэх шаардлагатай.

1731 онд Чин улсын элчин сайд Мантай Торгууд хаант улсад айлчлах үеэр, тэнд Шунутай биечлэн уулзаж, түүний байдлыг ойлгож өнгөрчээ. Шуну Мантайд хэлэхдээ “*миний эцэг намайг Лазаны хүү Галданданжинтай харилцан сайн (эргэлзээгүй), намайг Богд хаанд дагаар ормуй хэмээн гурван жил хорив, суллаад Хасагийг дайлан зургаан жил явав, Торгуудад ирээд долоон жил болов*”²⁶ хэмээсэн байдаг. Шунугийн ярьсан Лазаны хүү Галданданжин нь Цэвээнравданы хүргэн. 1714 онд Цэвээнравдан Төвөдийн Хошууд хааны удамтай давхар ураг барилдахаа илэрхийлэн, охиноо Лазаны хүү Галданданжинтай ураглуулж, Зүүнгарын хүргэн болгов. 1717 онд Цэвээнравдан охиныг хүргэнд хамгаалан Лхаст хүргэж байна хэмээн шалтаглан Төвөд рүү цэрэг оруулж, Лазан хааныг алаад, Хошууд хааны ордныг мөхөөн, Төвөдийг эзэлж, 1720 онд сая чингийн цэрэгт хөөгдөн Төвөдөөс гарав. Шунугийн яриаг үндэслэвэл, Шуну Галданданжины харилцаа сайн. Цэвээнравдан Галданданжинд итгэхгүй, тэр ч байтугай хорсол өвөрлөж, хожим энэ хүргэнийг цаазаар авжээ²⁷. Шуну түүнтэй ойр байсан нь мэдээж эцгийнх нь дургүйцлийг хүргэсэн байна. Шуну Мантайд мөн “*урьд миний эцэг намайг Лазаны хөвгүүн Галданданжинтай хамт Богд хааны газарт оргомуй хэмээн шоронд гурван жил хорив*”²⁸ хэмээн хэлсэн байдаг. Найралт төвийн наймдугаар (1730) онд оргон ирсэн Зүүнгарын оргодол Бургутын өчлөөр, Шунугийн энэхүү үг үнэн болох нь батлагдана. Бургут хэлэхдээ, “*Цэвээнравдан амьд байх үедээ Лазан ханы хүү Галданданжин болон Цэвээнравданы хоёрдугаар хүү Лувсаниуну нийлж их улсад бууж өгөх санаатай хэмээн сэжиглээд Данжин, Лувсаниунуг баривчлан хүргэж, Данжиныг цаазлав, Лувсаниунуг гурван жил гаруй хорив*”²⁹ хэмээжээ.

²⁶ Чин улсын Шинжааны манж архивын эмхэтгэл (нэг), 2012, Тал 250.

²⁷ Гаваншарав. Дөрвөн ойрадын түүх.(тод үсэг). Тал-255; Нэр тодорхойгүй. Дөрвөн ойрадын түүх. (тод үсэг), Тал-278. //Бадаа, Алтаншаа, Эрдэнэ эмхэтгэн тайлбарлав. Ойрад соёлын дээж. Шинжааны ардын хэвлэлийн хороо., 1992.

²⁸ “Чин улсын Шинжааны манж архивын эмхэтгэл” (нэг), 2012, Тал-255. Уг хэрэг орос сурвалжид өөрөөр тэмдэглэгджээ. Оросын элч Униковскийгийн тэмдэглэлээс харвал “Шуну Оросын Цагаан хаантай найрамдах санаатай, Цэвээнравдан найрамдахыг зөвшөөрөхгүй. Шуну өөрийн эцгээ сүрдүүлэн хэлсэн нь: Хэрэв Цагаан хаантай найрамдахгүй бол тэр өөрийн нагац аав Аюукыг түшин очин гэсэн учир Цэвээнравдан түүнийг ойрын хоёр жил хорив” (Униковский, И. XVIII зуунд их бууны цэргийн ахмад Шинжаанд үзэж сонссон тэмдэглэл, 1999, Тал-189) гэжээ. Шуну юм бүхэнд эцгээ эсэргүүцсэн эсвэл зүүнгарын хүн Униковскийд сайшаагдахын тулд ингэж ярьсныг мэдэх аргагүй ч Цэвээнравдан Шунуг хорьсон нь тодорхой байна.

²⁹ Найралт төвийн манж улаан цохолборт айлтгалын бичгийн бүрэн орчуулга (доод), 1996, Тал-1957.

Их Цэрэндондовын Төвөд рүү орох цэргийг дагалдсан Самдан бууж өгсний дараа, аль эрт Энх-Амгалангийн тавин наймдугаар (1719) онд өчихдөө, “*манай тайжийн эхнэр болбоос торгуудын Аюукын охин, түүнээс төрсөн бага тайжийн нэр Шуну, Цэвээнравдан ганц Галданцэрэнийг өхөөрдөн, Шунуг хамаарахгүй, эцэг хүү харилцан эегүй. Манай цэрэг ирсний дараа сонсоход, Бага Цэрэндондовтой нийлж Алтай руу дутаан гарсан нь мэдрэгдэнэ*”³⁰ хэмээсэн байдаг. Тэр жил Хөхнуурын Цагаанданжины хүргэн Равданы эцэг лам Намхайжамц Төвөдөд, сонссон мэдээгээ хэлэхдээ: Тэр үед Зүүнгарт Цэвээнравданы хүргэнээр орсон, Лазан ханы хөвгүүн Галданданжин, Сэтэржаваас төрсөн Лувсаншуну, Шунудаваа хоёрт хэлсэн нь: “*Цэвээнравдан миний эцэг Лазаныг алав, миний бие хэрэв энд байвал гарцаагүй хор хүртэнэ. Чиний зэрэг хоёр хүн ах Галданцэрэнд өш зангидав, байдлаас чиний зэргийг бас тагнан харахгүй бол, манай гурван хүн дутаан гарсан нь дээр, Торгууд руу буцан очъё зэрэг үгийг хэлэв. Галданданжины эм сонсоод, түүний эцэг Цэвээнравданд дуулгасны дараа, Цэвээнравдан өөрийн хоёр хүүг хорив*”³¹ гэсэн байдаг. Намхайжамцын үг үнэн зөвөөс үл хамааран, Шунугийн эцэг түүнийг Галданданжинтай хамт Чин улсыг түшиглэх гэж байна хэмээн сэрдэн хорьсон нь тодорхой, Зүүнгарын ард Цэвээнравдан Шунугийн харилцаа хурцадмал гэдгийг аль эрт мэдэж байжээ.

Шуну Хасагийг дайлаар гарсан нь түүхэн хэрэг. Шуну Мантайд хэлэхдээ: “*хулгана жил таны цэрэг орж ирмүй хэмээн сонсов, миний ялыг хэлтрүүлж Хасагт цэрэглэн илгээв. Би Хасагт очиж, дайлан авахыг нь авав. Тэнд зургаан жил суув, миний нутгаас Нэмэх*³² *нэртэй хүн ирээд хэлсэн нь: Чиний эцэг ах чамайг баримуй хэмээв. Би даруй зургаан хүнийг авч оргон гарч манай нутаг хасагийн хооронд олон газраар дамжин Хасаг руу орж, тэндээс торгуудад ирсэн учир ийм*”³³ хэмээсэн байдаг. Хулгана жил буюу 1720 онд, Чин улс Төвөд рүү цэрэг хөдөлгөн, Төвөдөд Зүүнгарын цэргийг цохиод, умард зам руу цэрэг илгээн Зүүнгараас сэргийлэв. Энэ явдлын тухай орос сурвалжуудад мэдээ бий. Униковскийгийн тэмдэглэлээс үзвэл, Цэвээнравдан сууринд байх үедээ олонтоо Хасагийг дайджээ. Цэвээнравданы ойрын хүн Хашиха (цэргийн түшмэл) Униковскийд хэлэхдээ: “*өнгөрсөн жил (1722) хунтайжийн хүү Шунудавааг илгээж хасагийн жүзийг дотлов, одоо*

³⁰ *Найралт төвийн манж улаан цохолборт айлтгалын бичгийн бүрэн орчуулга (доод), 1996, Тал-1414.*

³¹ *Найралт төвийн манж улаан цохолборт айлтгалын бичгийн бүрэн орчуулга (доод), 1996, Тал-1434.*

³² Шунуд нууц задруулсан Нэмэх нь Шунугийн харьяат бөгөөд өөр өөр хүмүүсийн өчлөөр батлагдаж байна.

³³ *Чин улсын Шинжааны манж архивын эмхэтгэл (нэг), 2012, Тал 255-256.*

(1723) уламжлан ирсэн мэдээгээр тэр хасагийг ялав, гурван хотыг эзэлж, 1000 өрх хасагийг авч ирж байна. Энэ 1000 өрхийн хүн удахгүй энд ирнэ, гурван хот бол: Ташкан, Сайрам, Хар мурут”³⁴ хэмээжээ. Униковскийгийн тэмдэглэл дэх Шунудаваа нь Лувсаншуну юм. Дээрх баримтуудаас үзвэл, Шуну хулгана жил буюу 1720 онд хасагт очиж, 1723 онд том ялалт олоод, үүнээс хойш 1725 он хүртэл хасагт байжээ. Өмнө нь дурдсан Чин улсад даган орсон Зүүнгарын Пунцагийн өчлийг үндэслэвэл, энэ жил Шуну хасагийн тэргүүн хүнтэй андгайлан, Хасагтай хамтран Зүүнгарын эсрэг холбоо байгуулж, өөрийн эцэг ахаас урвах гэжээ. Хэрэг илчлэгдсэний дараа Цэвээнравдан Шунуг баривчлахаар хүн илгээсэнд, Шуну ялаас айн Торгууд руу зугатсан байна. 1731 онд, Шуну Торгуудад ирээд долоон жил болсон тухайгаа хэлэв, тэгвэл тэнд хүрсэн хугацаа 1725 он болж байна. Энэ дүгнэлтэнд орос сурвалжийн баримт олдлоо. 1726 оны 2-р сард, Торгуудын дээд лам Шакур оросын хурандаа Беклемишевт хэлэхдээ, Шуну Зүүнгараас дутаан явсан шалтгаан нь, Галданцэрэн “цэрэг цуглуулан түүнийг цохих”-оос айсан учир тэднийг бараадсан гэжээ. Шуну найман хүнийг дагуулан, төрөл садан торгууд руу дутаан очсон байна³⁵. Тэр үед Шуну хэдийнээ Торгуудад ирсэн байсныг мэдэж болно.

Шунугийн дутаан гарсан хугацаа нь 1725 он, Цэвээнравдан 1727 оны хавар гэнэт нас барж, Шунугийн эх дүү нар нь Цэвээнравдан үхсэний дараа алагджээ. Цэвээнравдан амьд байх үедээ Шунуг гурван жил хорив. Цэвээнравдан Шунуд дургүйлхсэн нь, Галданцэрэнгээс сонссон хов жив биш, өөр шалтгаантай болох нь олон сурвалжаар батлагдана. Өмнөн дурдсан Болуугийн өчил нь хуурмаг болох нь тодорхой байна. Шунугийн хэлснээр зүүнгарын “улсын бүх цэрэг түүнийг хүндэтгэн, түүнийг (Шуну) эцгийн залгамжлагч болгохыг хүснэ” зэрэг нь өөрийгөө чимсэн худал үг төдий.

Хоёрт, Цэвээнравданыг хорлон алсан гол өдөөгч ба түүнд Шунугийн бүтээсэн дүр. Өмнөн дурдсан Болуугаас гадна Зүүнгарын ардын өчил, орос сурвалжийн мэдээн дэх гол явдал нь харилцан баталж, үндсэндээ бодит хэргийг үүсгэлээ: Сэтэржав Цэвээнравданыг хордуулан алсны зэрэгцээ Галданцэрэнийг алахаар төлөвлөв. Шунугийн ах дүү нарын энэхүү гэмт үйлдэл бүтэлгүйтсэнээр, Галданцэрэнгийн хатуу цаазлалыг хүртжээ. Галданцэрэн Сэтэржав болон түүний

³⁴ Униковский, И. XVIII зуунд их бууны цэргийн ахмад Шинжаанд үзэж сонссон тэмдэглэл, 1999, Тал 113-114.

³⁵ Оросын Гадаад бодлогын архив, Зүүнгарын данс, 1729, данс 8, хуудас 73.

хүүхдүүдийг алсан арга нь адил харгис байсан эсэхийг тодруулах боломжгүй. Цэвээнравданыг хөнөөсөн шалтгааны тухайд, Сэтэржав өөрөө хэлэхдээ, хунтайж зөвхөн ахмад хөвгүүн Галданцэрэнийг чухалчлан үзэх бөгөөд түүний хүүхдүүдийг “хүн гэж үзэх”-гүй учир хэмээсэн байдаг. Мөн чанартаа энэ удаагийн хэрэг нь Зүүнгарын ноёрхох эрх мэдлийн төлөө өөрөөр хэлбэл Шуну болон Сэтэржав нар эрх булаахаар яаран хөдөлсөнд оршино. Сурвалжуудаас үзвэл, Шуну болон Торгууд хааны ордон Цэвээнравданыг хөнөөх далд хуйвалдаанд шууд оролцсон байх магадлалтай. Златкины шинжилсэнчлэн, тэд тухайн үеийн Зүүнгар-Торгуудын худ ургийн хэлэлцээрийг ашигласан байх магадлалтай. Цэвээнравдан амьд байх үед, Шуну Зүүнгарын эсрэг Хасагтай холбоо байгуулсан нь³⁶, хэдийнээ эцэг ахаас тусдаа явахыг төлөвлөсөн байсны тайлбар, энэ нь Торгууд руу дутаан очих шалтгаан болжээ. Шуну дутаасны дараа түүний эх дотроос хамжин, Торгуудын элчийг ашиглан эх дүү нартайгаа хуйвалдах замаар, Цэвээнравдан эцэг хүүг нууцаар алах төлөвлөгөөг хэрэгжүүлжээ. Өмнөх судлаачид Чин улсын албан түүхэн дэх Зүүнгарын хандлага хийгээд Торгууд ардын аман зохиолын нөлөөг хүртсэний улмаас, бүгд Шунуг өрөвдөлтэй хохирогч хэмээн үзсэн нь, түүхэн үнэнтэй таарахгүй.

3. Чин улсын баруун умардыг байлдах бодлого дахь “үнэт бараа”

1723 онд Найралт төв сууринд суусны дараа Зүүнгар-Чингийн харилцаа намдав. Гэвч 1727 онд Цэвээнравдан гэнэт нас барснаар дотоодын самуун үүсчээ. Мэдээ Чин улсад уламжлагдмагц онцгойгоор чухалчлагдаж, Найралт төв хаан Зүүнгарын “газар хэдийнээ хоёр хуваагдсан”-ыг соргоогоор мэдэрч, Зүүнгарыг холоос дайлахаар эрс шийдсэн байна. Иймд, Лувсаншуну Найралт төв хаанд Зүүнгарын асуудлыг шийдэх нэгэн “үнэт бараа”, Чин улсын баруун умардыг байлдах бодлогын шатар дээрх чухал хүү хэмээн харагдсан байна.

³⁶ Зарим Зүүнгарын оргодол ардын өчилд, Шуну хасагийн бага жүз Абурхайл ханы охиныг эхнэрээ болгосон явдал дурдагдсан байдаг. Гэвч Оросын талын баримтанд үүнтэй төстэй мэдээ байхгүй. Энэ ургийн явдал нь болсон уу, үгүй юу? Хэрэв болсон бол аль онд болсон? зэрэг нь тодорхойгүй байна. Найралт төв хааны сонсон уг “дам мэдээ” сэжиглэлтэй, их жанжин Юе Жунчи үзэхдээ “Хасаг, Зүүнгартай хааны зарлиг шиг уг удмын өшөөтэй, өөлд хүн яав ч ислам шашины хүүхдийг эхнэр болгохгүй, хэрэв энэ явдал үнэхээр тохиолдон, Хасаг, Зүүнгарын өшөөтнөөс өшөө авахыг хүсч, Лувсаншунуг албаар тэтгэсэн үү, эсвэл Галданцэрэнгийн харьяат ардыг босгохын тулд уу гэдгийг тогтоох боломжгүй” (Тайваны ордны музей. Ордны архивын Найралт төвийн айлтгалын бичиг, 12-р эмхэтгэл. 2018. Тал-193. // 台北故宫博物院: 《宫中档雍正朝奏折》第12 辑。) гэжээ. Товчоор энэ асуудлын бодит байдал тодорхойгүй, шинэ материалыг судлах шаардлагатай.

Лувсаншунугийн хэргийн тухайд, Чин улс хэрэг үүссэн тэр жил Зүүнгарын элч Тэлэйгийн амнаас мэджээ. 1727 оны 12-р сарын 22-ны өдөр, Найралт төв хаан зарлиг буулгах үед Сычуань, Шанси мужийн захирагч Юе Жунчи хэлэхдээ, 12-р сарын шинийн 10-ны өдөр, Галданцэрэнгийн элч Бээжинд ирэв, “Хараад байхад Зүүнгарын ардыг Галданцэрэн ганцаар захирав, Лувсаниуну торгуудын газарт амьдарч байгаа, цэрэг дагуулаагүй, энэ газар хэдийн хоёр хуваагдав” хэмээсэн байдаг. Зарлигаар Юе Жунчи анхаарал тавин зураг бэлтгэн, нууцаар сонсгон айлтгасан нь: “хулгайн санаа, Цэвээнравдан зоргоороо оморхог тэрслүү, харанхуй бүдүүлэг, түүний ачлалгүй хөвгүүд харилцан эегүй, одоо дотоодын самуунгүй боловч Лувсаниуну холын торгуудад, Галданцэрэн ганцаар түүний ардыг захирав. Ах дүүгийн хооронд хэдийн хонзон үүсэв, ардын дэмжих эсэргүүцэхийг таашигүй. Манай цэрэг тохиолыг ашиглан шууд орох, харин илүү хүчээр эцтэл болой”. “Тэнгэрийн санааг илэрхийлэн боогдож, Шэнзу өвөг ивээж, харин ч Цэвээнравдан харанхуйд унан буруушаагдаж, түүний ачлалгүй хүү Галданцэрэн, Лувсаниуну харилцан хөндийрч, хурданаар ялагдах болов. Хэрэв тэр ах дүү эедэж, хүчээ нэгтгэн дахин Торгуудтай сүлбээлж дэмжлэг олвол, айж хэсэг зуур зохицуулахад амаргүй болно. Одоо энэ далимаар, манай цэрэг завшааныг ашиглан орон сөнөөх, эзлэн бүрдэх бүрэн найдвартай”³⁷ хэмээснээс 1727 (Найралт төвийн тавдугаар) оны сүүлчээр, Найралт төв хаан нэгэнт цэргийн хүчээр Зүүнгарын асуудлыг шийдэх бодлогыг нууцаар тогтоосон байсныг харж болно.

Найралт төвийн тавдугаар (1727) оны 12-р сарын шинийн нэгэнд, Халхын туслагч жанжин Цэрэн, зүүнгараас дутаан ирсэн урианхай Жавын мэдүүлгийг айлтгасан нь, “Лувсаниуну нэг түмэн цэргийг удирдан Хан, Хархайгаас дутаан ирэв, газрын ардыг хураан авав, үргэлжлэн Галданцэрэн цэрэг удирдан нэхэн ирэв, Лувсаниуну бас цэрэг удирдан угтан байлдав, Галданцэрэн зүрхшээн ойртоод буцав. Эдүгээ Лувсаниуну нар хэлэлцсэн нь: Бид хэрэв Оросыг түшвэл судар унших ёс адилгүй, хэрхэн аж зуух, хэрэв Хятадыг түшиж чадвал илүү сайн, мөн дайлах цэрэг элсүүлээгүй, хэрхэх нь сайныг шийдээгүй”³⁸ гэжээ. Энэ үед Найралт төв хаан Галданцэрэн ах дүү эе эвдэрснийг мэдэж байсан учир, Цэрэнгийн айлтгалд Чингийн ордныхныг чиглүүлэн хурдан шийдвэр гаргаж, нэг талаар Лувсаншуну руу зарлигаар хүн илгээн, хэрэв тэр түшин ирвэл “манай Богд эзэн лав хүлээн авна, чиний хэргэмийг нэр хүндтэйд хүргэж, чамд үржил шимтэй газрыг өгч хишигээр тэтгэнэ” хэмээв. Нөгөө талаар жанжин Басай нарт цэрэг хөдөлгөн дайнд

³⁷ Найралт төвийн хятад улаан цохолборт айлтгалын бичгийн эхмэтгэл, 11-р боть, Тал 314-315.

³⁸ Найралт төвийн манж улаан цохолборт айлтгалын бичгийн бүрэн орчуулга (доод), Тал-1536.

бэлтгэн, Галданцэрэн Шунугийн замыг нэхэж амдан тосвол, тэр үед Шунуг түр Заг байдраг, Маадай сүүл, Ээрхэн зэрэг газарт төвхнүүлэн бэлдэх зарлиг буулгав. Чингийн ордон мөн Басай нарт, тухайн газрын ёсыг ойлгох урианхай хүнийг Хан, Хархай газарт дагуулан очиж, уг газрын урианхай нарт зарлигийг ухуулан, Чин улс лавтай Шунуг хүлээн авч гүн хишгээр үлэмж тэтгэх тухай Шунуд тандан мэдээ сонсгуулж, эргэлзээг нь арилгахын тулд урианхай ардад нийтээр тараах зарлиг буулгав. Тэрч байтугай хэрэв Шуну үнэхээр түшин ирвэл, зарлигаар түүнийг Бээжинд оруулан хаанд бараалхуулах төлөвлөгөөг гаргажээ.³⁹ Үүнээс Шунуг хэрхэн чухалчлан үзэж байсныг харж болно.

Шуну Чин улсад даган оролгүй, Торгуудыг чиглэн очсоныг түүхэн явдал батална. Гэвч Чингийн ордон Шунуг ашиглах төлөвлөгөөг орхисонгүй. Найралт төвийн долоодугаар оны 3-р сард, Торгон цэргийг захирагч дотоод сайд Фурнайг Хязгаар дахиныг тогтоох их жанжин тавиад, умард замын цэрэг болгов. Сычуань, Шанси мужийг захирагч Юе Жунчийг Холхи дахиныг амаржуулагч их жанжин тавиад, баруун замын цэрэг болгоод, хоёр замаар Галданцэрэн рүү цэрэг хөдөлгөх зарлиг буулгажээ. Үүний зэрэгцээ гадаад бодлогын арга ухааныг хэрэглэж, тус оны 5-р сард, зарлигаар дэд сайд асан Тууши нарыг Орос руу элчээр явуулж, мэйрэний занги асан Мантай нарыг Оросын элчийн бүлгийг дагалдуулан, Торгууд руу илгээв⁴⁰. Туушигийн элчийн бүлгийг Петер II хаан ширээнд суусанд баяр хүргэх хэмээн нэрийджээ, гол зорилго нь Зүүнгарыг довтлох дайнд Оросын дэмжлэгийг олох байв. Мантай нар Торгууд хаант улсад айлчлан очихын зэрэгцээ Дундад азийн Буриад, Хасагт очихоор төлөвлөж, гол үүрэг нь Торгууд хаант улсын цэргийг Зүүнгар луу хөдөлгөхийг хичээх, Хасаг зэрэг ардыг Чин улстай хоршуулахыг чармайх, өөр нэгэн онцгой үүрэг нь Шунутай холбогдох байв⁴¹.

³⁹ *Найралт төвийн манж улаан цохолборт айлтгалын бичгийн бүрэн орчуулга (доод)*, Тал 1600-1601.

⁴⁰ *Чин улсын Хятад Оросын харилцааны архивын түүхэн материалын сонгомол түүвэр (нэгдүгээр түүвэр)*, Доод боть, Хятад бичгийн товчоо, 1981, Тал527-528,530-531.//《清代中俄关系档案史料选编》(第一编), 下册.中华书局. Мантайгийн элчийн бүлгийн тухай Ма Рухэн, Ма Дажөн. “*Найралт төвийн Торгуудад буулгасан зарлигийн бичиг*” ба Мантайгийн элчийн бүлгийг явуулсныг шалган өгүүлэх нь. Үндэстэн судлал. 1998. 1-р хугацаа. // 马汝珩、马大正: 《试论“雍正谕土尔扈特汗救书”与满泰使团的出使》, 《民族研究》。

⁴¹ Шунугийн тэмцэх ерөнхий бодлогыг тогтоон элч томилсны дараа, Чин улс Шуну Торгууд, Хасагтай хамтран Зүүнгар луу довтлохыг мэдэгдэх шаардлагатай болов. Найралт төв, хэрэв Шунугийн зөвхөн Зүүнгарын эзэн болох нь биелэгдэн, Зүүнгарын асуудлыг шийдэж чадахгүй байхаас эмээж, иймд энэ төрлийн хэрэг үүсвэл хэрхэн зогсоох бодлогыг хэлэлцэв. //刘锦-ийг үзнүү:《清代雍正朝的西北政策研究》, 中央民族大学博士论文, 2013. Тал 148-150. Найралт төв хаан бүгдийг олонтоо эргэцүүлсэн, Шунуд тухайн үед үүнийг хийх чадвар байгаагүйг түүхэн явдал гэрчилнэ.

Туушигийн элчийн бүлэг 1731 оны цагаан сард Москвад хүржээ. Оросын эрх баригчдад Чин улсын итгэмжлэх жуух бичгийг өгсөнөөс гадна, дөрвөн аман үгтэй очсон байна. **Нэгдүгээрт**, Оросын эрх баригчдад Чин улс Зүүнгар луу цэрэглэх дайны хэргийг дуулгаад, хэрэв Чингийн цэрэг Оросын хилийн ойролцоо дайтвал, Орос улс юуг ч бүү сэжиглэнэ үү. **Хоёрдугаарт**, Чин улс Зүүнгарыг байлдан дагуулах үед, хэрэв хатан хаан түүний зэргэлдээх газрын ямар нэгэн хэрэгцээ байвал, Чин улсын элч нарт мэдэгдэнэ үү, эдгээр газрыг Оросод өгч болно. **Гуравдугаарт**, Зүүнгарын хүн хэрэв дайны үеэр Оросын хил рүү дутаан орвол, Орос улс хүлээн авч тэднийг байлгаж болох ч, тэдний толгойлогч болон зайсныг Чин улсад тушаана уу. **Дөрөвдүгээрт**, Торгууд руу элчийн бүлгийг оруулж сайнаар хүргэнэ үү⁴² хэмээжээ. Чин улсын байлданы бодлогын хамгийн дээд зорилго нь, Зүүнгар улсыг мөхөөхөд энэ мэт аливаа зардал, зүүнгарын газар нутаг ардыг хамааруулан таслан өгөхөөс ч буцахгүй байсныг тодорхой харж болно. Дээрх дөрвөн мэдэгдэлээс сүүлчийнх нь, даруй Мантайгийн элчийн бүлгийг Торгууд хаант улс руу амжилттай оруулах, Торгууд хаант улсыг Зүүнгартай тэмцэх дайнд туслуулах, Шунугийн тэмцэлтэй хамтруулах байв. Оросын тал Чин улсын хүсэлтийг зөвшөөрсөн ч, өнөөдрөөс хойш хэрэв Торгуудтай харилцах шаардлагатай болбол, заавал Оросод мэдэгдэх, учир нь тэд “хатан хааны харьяат ард”, “хатан хааны буулгасан зарлиг болон зөвшөөрөлгүйгээр, тэд юу ч хийж чадахгүй”⁴³ хэмээн мэдэгджээ.

Мантай нар Торгуудад байсан нөхцөл байдлынхаа тухай, 1732 (Найралт төвийн аравдугаар) оны 3-р сарын шинийн таванд хоёр нугалбар бичиж, Найралт төв хаанд нарийн тайлан өгөв. Уг хоёр нугалбарыг Цэргийн тухайн газрын хуулбар дансанд буцаан хадгалсан нь, эдүгээ “Чин улсын Шинжааны манж айлтгалын эмхэтгэл”-ийн нэгдүгээр дэвтэрт оржээ. Түүний нэг нугалбарт, Торгуудад Мантай нарыг Аюук ханы бэлэвсэн эхнэр Дармабала, Аюукын залгамжлагч Цэрэндондов болон торгуудын бурхны шашны тэргүүн Шүхэр лам нар хүлээн авч дайлан шагнасан тухай нарийн тэмдэглэж⁴⁴, хятад орчуулга нь Хятадын Түүхийн Нэгдүгээр Архиваас эмхэтгэн гаргасан “Чин улсын Хятад-Оросын харилцааны түүхэн материалын сонгомол түүвэр”⁴⁵-ийн нэгдүгээр ботид

⁴² Николай Бантыш Каменский. *Орос Хятад хоёр улсын гадаад харилцааны сурвалжийн эмхэтгэл*, 1982, Тал 207-208.

⁴³ Николай Бантыш Каменский. *Орос Хятад хоёр улсын гадаад харилцааны сурвалжийн эмхэтгэл*, 1982, Тал 207-208.

⁴⁴ *Чин улсын Шинжааны манж айлтгалын эмхэтгэл (нэг)*, 2012, тал 261-269.

⁴⁵ *Чин улсын Хятад Оросын харилцааны архивын түүхэн материалын сонгомол түүвэр (нэгдүгээр түүвэр)*, Доод боть, 1981, тал 555-560.

оржээ. Үүнийг үндэслэвэл, Мантай нар Найралт төвийн есдүгээр оны 2-р сарын шинийн есний өдөр Москвагаас хөдөлж, 3-р сарын 30-ны өдөр Саратовд очоод, 5-р сарын шинийн долооны өдөр Торгуудын Улустун голын эрэгт иржээ. Мантай нар Торгуудад 18 өдөр саатсаны дараа мордож, 5-р сарын 26-ны өдөр Саратовд буцан ирээд, Туушигийн элчийн бүлэгтэй нийлэн буцжээ. Мантайгийн захидлыг, Чин улсын элчийн бүлэг Торгуудад очихоос өмнө, Оросын тал тэднээс чингийн ордны Торгууд илгээсэн бичгийн эхийг өгөх, аман үгийг мэдүүлэхийг шаардсан байна. Энэ нь Чин улсын хувьд зүй бус шаардлага байсан ч, Мантай нар “*хэрэв эхийг уншиж дуулахгүй бол энэ улам эргэлзээтэй болж, шинэ хүндрэл учирахад хүрнэ, биднийг очихыг зөвшөөрөхгүй, эсвэл Лувсаншунуд зарлиг буулгуулахаас зайлсхийж, бидэнтэй уулзуулахгүй, улам ч ашиггүй*”⁴⁶ хэмээн үзээд эх бичгийг өгч уншуулан, зөвшөөрөл олсны дараа Торгууд руу очихоор хөдөлжээ. Мантайгийн яриа дахин нэг удаа тэдний гол зорилго нь Лувсаншунутай уулзах байсныг баталж байна. Мантайгийн бичсэн хоёрдугаар нугалбар нь, Лувсаншуну тэднийг хүлээн авч уулзсан байдлын тусгай тайлан, агуулга нь өмнөх нугалбараас илүү нарийн, Лувсаншунугийн үйл хөдлөл нэг бүр, үг нэг бүрийг тэмдэглэжээ. Чин улсын элч болон Лувсаншунугийн ярилцсан агуулгыг бүх талаар нь ойлгохын тулд уг нугалбарыг бүтнээр нь орчууллаа:

Торгуудад зарсан мэйрэний занги асан боол Мантай нар хичээнгүйлэн айлтгах нь, сонсгон айлтгах учир. Боол бид таван сарын шинийн найманд, Торгуудын хан Цэрэндондовын нутагт буудлав, Дармабалаг гаргаж манай буудлын хэргийг харгалзан шийтгэх Эрхэм хашиха нэртэй хүн, Лувсаншунутай машид сайн учир, Лувсаншунугийн хүн Баянмөнх, Лувсанжимба, Шажин нарыг аваад, манай хамт очсон халхын тайж Гүнгэцэвээн, дэс мэйрэний занги Гүржавын буудалд орж гаран мэдээ аван явна. Гагцхүү тиймд Лувсаншунуг бидэнд нийлүүлсүгэй хэмээн хэлсэн билээ.

Арван гурванд торгуудын зайсан Дэнжин, Лувсаншунугийн хүнийг авч ирэн бидний буудалд ирээд, Лувсанжимба, Шажин нарын хэлсэн нь: Манай тайж Шуну, биднийг зараад элч сайдуудын сайныг асуу хэмээв. Бид “манай бие сайн. Таны тайж сайн уу?, бидний дотор сонссон нь, Лувсаншунуг Зүүнгараас зайлаад хэд хэдэн жил болов. Хаана байгааг мэдэхгүй билээ, энд ирээд сая мэдэв. Эх дүү нар цөм хүнд алуулж, басхүү ийнхүү байгаа эр маш бэрх болсон төдий, үгүй бол зовсоор үхэх билээ” хэмээсэнд, Лувсанжимба өгүүлэн, “манай тайж тиймд, сайдуудыг нийлсүгэй хэмээмүй” хэмээсэнд,

⁴⁶ Чин улсын Шинжааны манж айлтгалын эмхэтгэл (нэг), 2012, тал-262.

манай үг “сайн, нийлсүгэй хэмээвээс болохгүй хэмээх газаргүй. Чиний тайжийн үг “дайн хэмээгч Галданцэрэн, манай газарт мөн Галданцэрэн. Нийлэхэд юу буй” хэмээв.

Арван дөрөвний үдэш Лувсанжимба, Шажин нар ирээд өгүүлэн, “манай тайж элч сайдуудын сайныг асуу хэмээн зарав. Зохиоос даруй энэ мэт амьтайхан болтугай хэмээн бэлэг чихэр нэг хэсэг илгээжээ”, бидний үг “эцэстэл энэ мэт болтугай” хэмээн өгүүлээд хүлээн авч идэв. Лувсанжимба өгүүлэн, “манай тайж сайдуудыг нийлсүгэй хэмээх санаа машид яармуй”, бидний үг “сайн, бид нийлвээс, манай үгэнд Шуну түүнд тус болох, Шуну түүний үгэнд бидэнд тус болох явдал байваас байх” хэмээсэнд, Лувсанжимба нарын үг “гагцхүү манай тайжийн биед баас хэмээх яр байж ирвээс бэрх”, үүнд бидний үг “чиний тайж зовлонд тохиолдсон хүн, бид зүйн түүний тэнд очвоос зохих билээ. Гагцхүү бид хөдлөн оросын Пол Поладни, хасагийн цэрэг, намайг даган ирсэн Сарва, торгуудын тайж зайсан бүгд хоёр зуу үлэх хүн дагах билээ. Учиргүйд орос, торгуудад сэжиглүүлмүй”, Лувсанжимба өгүүлэн, “машид мөн, бид очоод манай тайжид хэлсүгэй” хэмээв.

Арван долоонд Лувсанжимба ирээд хэлэн: “Манай тайж намайг зараад элч сайдуудад хэл, оросын Пол Поладнигийн буудалд нийлсүгэй, түүнээс сайдуудын буудалд очсугай” хэмээв. Бид “болмуй” хэмээн хэлээд илгээв. Оросын Пол Поладнид “чиний буудалд цай уумуй” хэмээн хэлээд, залган зайсан Дэнжин, хиа Дашийг аван очвоос, Шуну тэнд суужээ. Бид асуун, энэ хэн хэмээсэнд, Пол Поладни өгүүлэн, “энэ даруй Зүүнгарын Лувсанишуну” хэмээв. Бид асуун “тайж чамайг зүүнгараас зайлж хэд хэдэн жил болов хэмээн сонссон билээ. Энд ирсэний дараа чиний энд байгааг сая мэдэв. Эх дүү нар цөм хүнд алуулж, чи хэрхэн амьдрал. Чи маш эр бэрх болсон төдий, эдүгээ жарган амьдрах болой” хэмээсэнд, Лувсанишуну түүний өвчүүг заан хутган өгүүлэн, “үхсэнгүй нь чухам тэнгэр үүнийг бас амьдруулсан хэмээмүй юу”, бид асуун “чи ирээд хэдэн жил болов, Хасаг, Астак хэмээх улс таарчээ. Чи хэрхэн өнгөрөн гарав” хэмээсэнд, Лувсанишунугийн үг “миний эцэг намайг Лазаны хүү Галданданжинтай сайн, Богд хаанд дагамуй хэмээн гурван жил хорьсон билээ. Тавиад хасагийг дайлуулан зургаан жил явав, Торгуудад ирээд эдүгээ долоон жил болов” бас нэлээд сул үг өгүүлэн суугаад, бид өгүүлэн “манай буудал ойр, Шуну чи орж цай уун яв” хэмээсэнд, Шуну “сайн, орсугай” хэмээв. Бид оросын Пол Поладниг заан “манай буудалд ирээд жимс цай архи өргөн

уулган идүүлэн сул үг нэлээд өгүүлэв. Оросын Пол Поладни босоод одсугай” хэмээхэд, Лувсаниуну мөн босоод өгүүлэн “халх нар угаас миний нагац болмуу. Миний хоёр нагацын буудалд ороод үзсүгэй” хэмээн гараад Гүнгэцэвээний буудалд оров. Удан сууж бас Гүржавын буудалд ороод шөнө дунд хүртэл өгүүлэн суусанд, торгуудын зайсан Дэнжин, Шунугийн зүг өгүүлэн “Шуну ирээд элч сайдуудад нийлж нэлээд удан суув, гэрийн зүг хойш буцваас зохимуй” хэмээсэнд, Шунугийн үг “энд хэвтэвээс болох болой. Угтаа таны энд ирсэний дараа Бали Абагайн гэр, эсвэл чиний гэрт хэвтэх билээ. Эдүгээ элч сайдуудын хажууд хэвтэвээс нэг адил” хэмээн хэлээд, даруй Гүржавын буудалд хэвтэв.

Шөнө хэлсэн үг “хоёр нагацтай өгүүлэн суух санаа их буй. Энэ орос, торгуудын хүний өмнө өгүүлвээс болохгүй” хэмээж, Шуну оросын хоёр тулмач⁴⁷, торгуудын тайж зайсан нарыг та түр гар хэмээн гаргаад хэлсэн нь “энэ өдөр элч сайдуудад нийлж нэлээд удан өгүүлэн суувч хүн үлэмж болох тул санаа гарган өгүүлсэн явдалгүй, эдүгээ хоёр нагацыг нийлж суусанд би хэлсүгэй. Угтаа монгол, өөлд хэмээгч сайнаар найралдаж амьдарсан билээ. Галдан халхуудыг дайлан самуун явав хэмээн сонсов. Би нас бага учир мэдэхгүй. Эдүгээ их элч ирээд энд учирсаныг даган, таны авчирсан надад хэлэх үг бий юу” хэмээсэнд, Гүнгэцэвээн, Гүржав нарын үг “манай сайдууд надад тушаасан нь “бид Лувсаниунуг нийлсэний дараа түүнд хэлэх үг буй, нийлсэн цагт бидэнд чөлөө үгүй учир, манай өгсүгэй хэмээх бичгийн доторх үгийг та Лувсаниунуд хэл” хэмээсэн билээ” хэмээн бичгийн доторт бүхий чиний эцэг ахын явсан хэрэг чамд хамаагүй хэмээх зэрэг хэргийг мушгин хэлэв. Бас Лувсаниунугийн зүг “чиний өгүүлсэн угтаа монгол, өөлд сайн амьдарсан хэмээсэн нь үнэн, тэр хооронд Галдан халхуудад хэрэг дэгдээн явж, хожим манай Богд эзний их цэрэгт ихэд даруулж, түүнийг мэгүүтэж үгүй болов хэмээн сонсов. Эдүгээ манай халхууд Богд эзэн тэнхрүүлэн тэжээв, өршөөн хүмүүжүүлэв, хишгийг хүлээж, өөр өөрийн уг нутагт сууж, машид тайван амгалангаар жарган амьдрахыг чиний бие сонссон нь болой. Энд чамайг нийлсэнийг даган, манай санааг чамд хэлсүгэй. Шуну чи, чиний ах Галданцэрэнд цухалдаж орших газаргүй учир Торгуудад ирэв. Торгууд чиний нагац боловч, оросын газарт сууж, орост маш түшин итгэснийг даган, Шуну чи энд байсаар өөр зүйлийн жинд орвоос, хойч өдөр хэрхэж хүнд даргалуулж, газар

⁴⁷ Манжаар “tulmeci” гэж бичсэн нь манж толинд байхгүй. Энэ үг эртний словак хэлний үгийн санд байх бөгөөд одоогийн орос хэлнээс хэдийн замхарсан ч бусад словак хэлэнд хадгалагдан үлджээ. Жишээ нь украин хэлээр орчуулбал “тлумач”, голланд хэлээр орчуулбал “tunacz”.

орныг эзэлвээс болмуй. Эд нар ашигийг бодон их хэргийг хичээхгүй учир хүн үүрд амьдармуй юу, тухайг адилтгаваас болохгүй болой, үүнийг чи мэдэхгүй хэмээх газаргүй. Бидний санаанд Шуну чи эр басхүү сайн, үнэнч санаагаар чин биширэн манай Богд эзний цог буянд түшиж явбаас сайн нэр олох бөлгөө, үүрд жарган амьдармуй. Үүнээс сайн нь бас бий юу” хэмээсэнд, Шунугийн үг “таны энэ үгийг би мэдэв. Шуну би эцэг ахад цухалдаж энд ирэвч, миний санаанд хэн ямар болтугай, гагцхүү бурхан Зонхвагийн шашиныг бадруулах, хамаг амьтныг жаргуулах хүн болбоос би тэрийг санамуй. Гагцхүү дайн хэмээгч сайн хэрэг бус. Урьд дайн дэгдээн явсан миний өвөг Галдан өнөөдөр тасрав. Эдүгээ Зүүнгар миний эцэг үгүй болов, бид ах дүү хэд хэдэн хүн билээ, бусдыг Галданцэрэн цөм алав. Үлдсэн бид авчиран явсаныг нь та цөм мэдэв. Би санасан бүр гагцхүү Алтай, Хангай газарт түшиж жарган суухыг эрэн санамуй” хэмээв. Гүнгэцэвээн, Гүржавас бас өгүүлсэн нь, “чиний үгэнд өнөөдөр сайдуудыг нийлсэнд хэлэх санаа үлэмж билээ, чөлөө олохгүй хэмээжээ. Өглөө манай сайдуудад нийлвээс чамд ихэл тустай үг хэлмүй за” хэмээсэнд, Шуну “машид мөн, би эрхгүй нийлээд хойш одмуй” хэмээв. Тэр шөнө энэ тэрийг өгүүлэн, бэлэг хэмээн инээн, түүний бие дуулан бас сайнаар учирсаныг дуулуулж, уулцан өгүүлэн, даруй Гүржавын буудалд хэвтэв.

Дараа өдөр арван наймны өдөр дундад бидний буудалд авч ирээд будаа уулгав, будаа идэн бараад, Лувсаншуну хүнийг зайлуулаад асуун, “хаан хоёр замд элч зарсан учрыг манд хэлвээс болмуй юу” хэмээн асуусанд, бидний үг “манай их эзэн, Орос улсын Цагаан хаан шинэ суув, Торгуудын Цэрэндондовыг шинэ суусан баярын ёсонд тусгайлан хоёр замаар элч зарав” хэмээсэнд Лувсаншунугийн үг “хэрэв Шунугийн тулд ирсэнгүй юу, би тойрон үзэв, цөм мэдэжээ, би гагцхүү хааныг санамуй” хэмээв, бидний өгүүлсэн нь “чи үнэхээр Богд эзнийг чин биширэн санаваас, хязгаарын этгээдээс манай цэргийн мэдээг олон, эндээс даруй давшин хөдөлвөөс зохимуй. Хэрэв манай жанжин сайдууд бид чамайг итгэхгүй халгахгүй тул далдлан санаваас бид чамд тэмдэгт бичиг өгөх. Манай жанжин сайдууд эрхгүй чамайг итгэн халгамуй” хэмээсэнд Лувсаншуну өгүүлэн, “би хаанахын цэргийг авч очмуй. Эд торгуудыг би цөм мэдэв. Хоёр эм хүүхэд, хэд хэдэн ач нар алуулсаныг нэгмөсөн санахгүй. Тэрч байтугай энэ хооронд дайн улс хэд хэд тааралджээ, цэрэггүй хэрхэн очмуй” хэмээв, бидний үг “Шуну чи энд үгүй болбоос бид харин чиний байгаа газрыг асууж чамд бичиг илгээсүгэй хэмээн бичиг цөм бичжээ. Чи үзэх үү” хэмээсэнд,

Шуну өгүүлэн “монгол бичгийг би асар тодорхой танихгүй, Гүржав нагац чи дуудаж сонгосугай” хэмээсэнд, Гүржав дуудаж сонсгуулав. Бид асуун “Шуну чи цөм сонсов. Бидний санаа, энэ бичгийн доторх учрыг чи цөм мэдсэн болой, чи хэрхэмүй” хэмээсэнд Лувсаниуну өгүүлэн “би юу гэх, миний эцэг болой, би бас тэмцвээс болмуй юу” хэмээв. Бидний үг “Шуну чи санан үз, чиний энэ мушгин өршөөсөн хэрэгт хэн туслан чадмуй. Манай Богд их эзнээс гадна бас чадах хүн байна уу? чи үнэхээр үнэнч санааг гарган хичээнгүйлэн бичиг бичээд өг. Бид хойш очоод манай Богд эзэнд чиний мушгин өршөөсөн хөөрхий учрыг сонсгон айлтгаваас Галданцэрэнийг мохуулсаны дараа чамайг тэр нэг аймгийн тэргүүн болгохыг болзвоос болохгүй” хэмээсэнд Лувсаниуну өгүүлэн “би бичиг өргөн барьсугай, элч сайдууд миний үед айлтгах уу” хэмээв. Залган бидний зүүсэн хавтагийг хамт ав хэмээсэнд, бид шинийг нь нэг хоёр өгөх хэмээвээс болохгүй, мушгин нэг тайлж аваачив. Гарч ороход хоёр нагац миний гэрт очих уу хэмээн өгүүлээд очив. Тэрнээс хойш боловсронгуй болж надад байгааг үзэн хүн зараад ав хэмээн юм авч аваачмуй.

Хорин нэгэнд тайж Гүнгэцэвээн, дэс мэйрэний занги Гүржав түүнийг үзээр одсонд, Лувсаниунугийн хэлсэн нь “би урж өдөр элч сайдууд таныг учирч их төлөв үг сонсов. Таны хойш буцах өдөр ойр олов. Энэ чөлөөнд надад бас хэлэх үг бий юу” хэмээсэнд Гүнгэцэвээн, Гүржавын өгүүлсэн нь “манай сайдууд урж өдөр чамд тус болох үгийг цөм хэлэв, бид хойш морьдох өдөр ойр болсоныг даган Дээр айлтгах бичгийг хэзээ сайдуудад тушаамуй. Манай элч сайдууд ирсэн энэ сайн даирамд, аливаа учрыг сийрүүлэн өгүүлж санааг машид тогтоож, манай Богд эзэнд уламжлан айлтгаваас хожим чамд тус буй. Санаа үг байваас чи энэ чөлөөнд надад хэл, бид буудалд очсоны дараа сайдуудад хэлсүгэй” хэмээсэнд Шунугийн үг “айлтгах бичгийг бичин завдаагүй, элч сайдууд таныг учирч миний санааг хэлэхгүй бол хожим хэнд хэлмүй. Урьд миний эцэг намайг Лазаны хүү Галданданжинтай хамт Богд хааны зүг оргомуй хэмээн гурван жил хорив. Хулгана жил таны цэрэг орон ирмүй хэмээн сонсоод миний ялыг өршөөж хасаг газарт цэрэглэн илгээв. Би очоод хасагийн ардыг дайлан авахыг нь авав, тэнд зургаан жил суусан билээ. Манай нутгаас Нэмэх нэртэй хүн ирээд хэлсэн нь, “чиний эцэг ах чамайг барьмуй” хэмээн хэлсэнд, би даруй зургаан хүнийг авч оргон гараад, манай нутаг хасагийн нутаг хоорондуур тойрон яван, засан хасагт ороод, тэрнээс торгуудад хүрч ирсэн учир энэ. Хасаг газарт орж Алтай замаар Богд хааныг эрэн одсугай хэмээн санасан билээ. Алтай замыг манай цэрэг дайлан авчээ

хэмээн хасагаас ирсэн оргодлоос сонсов. Тиймийн учир гагцхүү зуны дээл чинээ нэг өмсжээ. Тиймийн учир, торгуудад хурч ирэв. Миний энэ оргон гарч явсан явдлыг, таны газарт сонссон уу үгүй” хэмээн асуусанд Гүнгэцэвээн, Гүржавын хэлсэн нь “манай газарт сонссон билээ. Чамайг тусгайлан энэ торгуудад ирсэнийг мэдэхгүй. Оргон гарч Хан, Хархайн зэрэг газарт суужээ. Манай Дундад улс, Торгууд, Хасаг альд орохыг мэдэхгүй хэмээн өгүүлэхийг сонсов. Чи хэрэв манай Дундад улсын их Богд хааныг эрэн орсон байваас манай Богд эзэн төрөлх өршөөнгүйт олныг тэжээх зохиоход бахтай, эрхгүй чиний дуртай газарт чамайг суулган, дээд нүүртэй болгон хишиг хүртээх билээ. Бид учирснаас нааш санаа нийлсэн учирт чамд хэлмүй. Урж өдөр манай сайдууд чиний энэ явсан нь зүй буюу, машид хөөрхий хэмээн, үнэнч санаа гарган чамд хожим тус болтугай хэмээн өгүүлсэн үг буй. Тиймийг даган аливаа хэлэх үг байваас бидэнд хэл, би буудалд очсоны дараа сайдуудад хэлэхэд сайн” хэмээсэнд Шунугийн үг “миний санааг таньд огт далдлах явдалгүй. Миний ах Галданцэрэн, эцгийг хорлож, харин ч миний эх, дүү нарыг хорлов хэмээн нэр тулгаад цөм алжээ хэмээн энд ирсэний дараа сонсов. Энэ хэргийг лам гурван эрдэнэ бөгөөд их Богд хаан тольдохоос бус бусад туслан чадмуй хэмээн түүний санаанд нэгмөсөн үгүй, би энд ирсээр долоон жил болов. Эдүгээ боловч миний эх торгуудын охин хүүхэд, хол өвөг Аюук хан, миний ирэх урьд үгүй болжээ. Хожим ач нар хүүхдүүд миний эхийн энэ хэрэгт очсугай хэмээвч энэ хооронд тэдний дотор найргүй болж, тогтсон санаагүй, миний хүчээр дайлан очсугай хэмээвээс хүч дорой, орост цэрэг гуйсугай хэмээх санаа буй, надад хэрэв орос цэрэг өгч илгээв хэмээн сайн муу болохыг болзвоос болохгүй бөгөөд хожим намайг Зонхвагийн шашнаас хол болгохыг болзвоос болохгүй. Тиймийн учир торгуудын зүг огт өгүүлсэн явдалгүй, он хүлээн суужээ. Би ирснээс манай энэ торгуудын нагац нарыг үзвээс их төлөв орост орсон байдал буй. Угтаа Дөрвөн ойрад хэмээгч их нутаг билээ. Энэ торгууд хуучин өөлдийн ёсыг алдаж, бусармаг ёс хэмээвээс бус, орос ёсонд нийлүүлэн явмуй юу хэмээвээс бас өөр, өөлдийн хуучин ёсыг гээж дундуур болжээ. Энэ мэт байсаар орост цухалдаж шашин ном өөр болохыг болзвоос болохгүй. Тиймийн учир эдүгээ надад нэг санаа буй, таныг очсоны дараа би торгуудын нагац нарт гуйн хэлэх үг буй, сонсвоос Богд хааны их цэрэг Зүүнгарт дайлан ирмүй хэмээмүй. Надад туслан хэдэн мянган цэрэг өгөх үү, миний нутгийн зүг очоод миний харьяат хүнийг хайн үзсүгэй. Хэрэв үүнийг болохгүй хэмээвээс тусгайлан санааг гаргаад хэлэх үг үлэмж, цэрэг өгөх нь бэрх хэмээвээс намайг

өршөөн хоёр гурван зуун цэрэг өгч намайг Хангай зүг хүргүүл, тэнд очсоны дараа миний буяныг үзсүгэй хэмээн хэлмүй. Миний энэ санаанд орж цэрэг өгч явуулаас тухайг үзсүгэй. Цэрэг өгөхгүй, миний санаанд болохгүй болбоос надад аргагүй, чөлөө завдахыг үзээд миний заяа гуйхаас гадна өөр аргагүй болмуй. Гагцхүү миний санах нь Зонхвагийн шашныг барьж үүрд амьтныг жаргуулах, багасын санаанд амруулан нийлүүлэх, өршөөн Алтай Хангайд түшүүлэхийг гагцхүү их Богд хаан тольдох, миний буян заяаг үзэхээс бус, миний адгийн санаа энэ” хэмээв. Бас өгүүлсэн нь “миний таньд хэлэх нэг үг, хэрэв намайг орос замаад ирээ хэмээвээс таны улсын зүг орос улс машид найртай хэмээн сонсов. Хэрэв эд зам өгөхгүй болбоос бага миний учирт хоёр улсын найртайд хэрхэж болмуй. Би торгуудад ирсээр даруй Цагаан хаанд миний ирсэн учрыг мэдүүлсэнд, Цагаан хааны үг “чиний энэ хэрэгт би тусалсугай” хэмээсэн билээ. Түүнээс хойш торгуудаас Москвад элч зарахад, би мөн хүн цуг илгээмүй. Миний тэр санаа мөн хэмээвээс би торгуудад орсон хүн бөгөөд элч зарахгүй болбоос надад тусгүй юу хэмээн хүн зарсан учир энэ, миний өгүүлсэн эл үг, бичиг айлтгасныг орос сонсвоос даруй надад муу болмуй. Санааны дотор байгаа үгийг цөм таньд хэлэв, үүнийг элч сайдуудад хэл, та санааны дотор суулгаж од” хэмээв.

Хорин хоёронд Дармабалагийн хуримнаас буцсанд шөнө бас эрт болж боол бид зөвлөлдөөд Шуну Зүүнгар бөгөөд манай буудалд цээрлэлгүй ирж идэн суун шөнө хэвтэх, бид түүний гэрт очихгүй болбоос Шуну Торгуудад суухгүй болмуй хэмээн бид очсонд, Шуну гэрт лам нарт жин дуудуулмуй. Намайг өөр гэрт оруулж цай уулган сул үг өгүүлэн суув. Оросын дундаас гарсан чөлөөнд бид өгүүлсэн нь, “Богд эзэн Шуну чамайг эрхгүй орос замаар авсугай хэмээх болбоос чиний өчнөөн хөтөч, чи хэнийг авмуй, хэдийг авмуй” хэмээсэнд Шунугийн үг “би хэдийг авмуй” хэмээсний дараа бусад цөм сэтгэл хүйтэн болж тарахад хүрч одмуй. Надад бүхий хүний нэрийг цөм бичээд өгсүгэй. Үнэхээр орос зам болбоос хэдэн хүн авбаас, тэргүүнээс тоолон аваачваас үлдсэн хүн хөдлөхгүй болмуй хэмээн өгүүлж, салах ёсоор тэврэлдээд хойш ирэв.

Хорин дөрвөнд, буудалсан газарт айлтгах бичиг хүргэж ирсэнд Шуну түүний гэрийн хүний нэр тоог мөн хүргэж ирэв, Саратовд ирсэнд Лувсанжимба, Шажин, Арслан нар өгүүлсэн нь, “манай тайж Шунугийн үг сайдуудад хэл “орос замаар болбоос их улсын хамт орос улс машид найртай

сайн, энэ найрыг эвдэхэд Шуну би үлэмж аймуй, надад мөн ихэл тусгүй” хэмээв. Бас Живзундамба хутагтад илгээсэн бичиг бэлэг, түшиэт хан Ванжилдорж, ван Данжиндорж, ван эфү Цэрэнд илгээсэн бичиг бэлэг, Засагт хан Цэвээнжав, бэйл Бобайд илгээсэн бичиг, бэлгийг цөм надад тушаажээ”. Тиймийн учир Лувсаншунуг нийлэв, тэр хүн зайлуулж өгүүлсэн үг учрыг сонсгон айлтгав. Найралт төвийн аравдугаар он, гурван сарын шинийн таван Мэйрэний занги асан уг зэрэг шагнасан боол Мантай, мэйрэний занги асан уг зэрэг шагнасан боол Асхай⁴⁸ гэжээ. Энэхүү урт тайлангаас бид доорх хэдэн зүйлийг нэгтгэн дүгнэж болно.

Нэгдүгээрт, Лувсаншуну Торгуудад ирсэн үйл явц. Шунугийн ярьснаас үзвэл, Шунуг гурван жил хорьсны дараа Хасагийг дайлуулахаар явуулжээ. Зургаан жилийн дараа, түүний итгэмжит хүн Нэмэх тал нутгаас ирэн, Цэвээнравдан эцэг хүү түүнийг барих гэж байгааг мэдэгдсэн боловч, юуны тулд барих гэж байгааг тодорхой дурдаагүй байна. Шуну мэдээг сонссоны дараа зургаан хүнийг авч оргон гараад, Хасаг болон түүний нутгийн хооронд олонтоо явж, дахин Хасаг руу ороод, тэндээс Торгууд руу оргон очжээ. Шуну хэлэхдээ, Хасагийн газрыг өнгөрч Алтайд хүрээд, Алтайн дагуух замаар Чин улсад түшин очих гэсэн боловч Зүүнгарын цэрэг Алтайн замыг тосон суусныг сонсоод, Торгуудыг түшихээр шийдсэн байна. Энэ нь өмнө эш татсан Халхын эфү Цэрэнгийн мэдүүлсэн агуулгатай таарна. Цэрэнгийн айлтгалд, Шуну Хан, Хархайн газарт дутаан ирэв, Чин улсыг түшихээр төлөвлөж байна хэмээсэн байдаг. Хан, Хархай нь Хан болон Хархай гэх хоёр өөр газар бөгөөд Зүүнгарын умардад, Эрчис голын умард салаа урсгалын Хатан голын баруунаас, одоогийн ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах Улсын баруун хэсэг, Алтайн хилийн өмнөд хэсэг орчимд буй. Шуну шууд Алтай, Хангайн орчмын газарт хүрч, тэнд тайван аж төрөхийг хүссэн бөгөөд Шунугийн хуучин нутаг Зүүнгарын умард хил, Алтай орчмын газартай холбогдсон байж магадгүй.

Хоёрт, Чин улсын Лувсаншунуд агуулсан эрмэлзлэл болон баримталсан арга хэмжээ. Мантайгийн элчийн бүлэг Торгуудад очсон гол зорилго нь Шунутай ойртож, хамгийн сүүлд түүнийг ятган Мантайтай хамт Бээжин ирүүлэх байв. Мантайгийн элчийн бүлэг дэх хоёр халх тайжийг, Шуну нагац гэж дуудсан нь, Аюукын нэг эхнэр халх гаралтай, тэр нь Сэтэржавын төрсөн эх. Үүнээс Чин улс Торгууд руу элч илгээхдээ, маш нямбай бэлтгэснийг харж болно. Мантайгийн элчийн бүлэг гол нь энэ хоёр хүнээр дамжуулан Шунутай харилцаа тогтоох байв.

⁴⁸ Чин улсын Шинжааны манж айлтгалын эмхэтгэл (нэг), 2012, Тал 248-260.

Мантай Шунуд өгөхөөр монголоор бичсэн Чин улсын захидлыг (хааны зарлиг эсвэл ГМТЗЯЯ-ны захидалын аль нь болох нь тодорхойгүй) авч очсоны зэрэгцээ түүнийг нэн даруй зүүнш буцан хөдөлж, Чингийн цэрэгтэй нийлэн дайтах хэрэгтэй хэмээн ятгажээ. Чингийн цэргийн жанжин болон Лувсаншунугийн хооронд эндүүрэл үүсгэхгүйн тулд, Мантай бэлтгэсэн тамга дарсан батлах захидлыг Шунуд өгсөн байна. Чин улс Шунугийн сэтгэлийг туйлаар хөдөлгөн амалсан нь, *“Галданцэрэнийг мөхөөсний дараа зарлигаар чамайг нэг хэсгийн тэргүүн болгоно”* хэмээв. Энэ нь Шунугийн өдөр шөнөгүй хүсдэг мөрөөдөл. Чин улс Шунуг татахын тулд маш том шийдвэр гаргасан нь илэрхий харагдана.

Гуравт, Шунугийн Торгууд дахь хүндхэн байдал болон Чин улсын талаарх байр суурь. Шуну болон Чин улсын элчийн ярианаас, Шуну Торгуудад хүндхэн байдалтай байсан нь тодорхой харагдана. Шуну ярихдаа, Торгуудад ирэхээс өмнө Аюук хан хэдийн нас барж, түүний үр ач Сэтэржавын өшөөг авах сэтгэлтэй боловч, дотооддоо нийцгүй бөгөөд Зүүнгар луу цэрэг хөдөлгөсөнгүй хэмээсэн нь үнэн хэрэг. Аюук хан нас барсны дараа түүний үр ач хаан ширээний төлөө илд далдаар тэмцэлдэн, Зүүнгарыг анхаарах завгүй байв. Шуну мөн *“би өөрийн хүчээр цэрэглэхийг хүсэвч ганц хүч өчүүхэн”* хэмээсэн байдаг. Шуну зургаа, долоо хүнийг авч Торгуудад ирсний дараа олон хүн элсүүлж чадаагүй мэт. Тэрбээр оросоос цэрэг зээлэхийг хүсэвч, Орост бүрэн эрхшээгдэн, арга буюу шашин шүтлэгээ өөрчлөхөд хүрэхээс айжээ. Шуну нагац торгуудад туйлаар урам хугарч, тэднийг *“бараг орос руу орох байдалтай”* хэмээн үзсэн байна. Оросын эрхшээл доор, тэд торгуудын *“хуучин ёс”*-ыг огоорч, муслимтай ч адилгүй, оростой ч адилгүй, этгээд болжээ. Оросын эрх баригчид Мантайд, хэрэв Оросын зөвшөөрөлгүй бол, торгуудууд ямар ч хэргийг өөрөө шийдэж чадахгүй хэмээн шийдэмгийгээр мэдэгдсэн нь үнэн хэрэг болох нь илхэн.

Дөрөвт, Шуну Мантайд хэлэхдээ: Тэр торгуудаас хоёр гурван мянган цэрэг зээлэн, буцан очиж хуучин харьяатаа олоод, манжийн цэрэгтэй хоёр талаас Зүүнгарыг хавчин довтлоно. Хэрэв Торгууд зөвшөөрөхгүй бол тэр хоёр гурван зуун цэргээр Алтай газарт хамгаалан хүргүүлээд, Алтай Хангай орчим толгой хорогдох газар олохоор төлөвлөжээ. Хэрэв энэ хоёр эрмэлзлэл ор хоосон болж өөрчлөгдвөл, тэр арга мухардах байв. Чин улсын элч түүнд, хаан элчийн бүлгийг оросоос зам гуйлган, түүнийг Бээжинд аваачих бодолтой байгааг мэдэгдэх үед, Шуну хамгийн сүүлд энэ хэргээр Орос-Чингийн найрамдалт харилцаанд доог болж, түүний хувьд уг хүнд ашиггүй үг болох учир Чин улсын хүсэлтийг эелдэгээр

эсэргүүцжээ. Мантайгийн бичсэн Найралт төв хаанд өгсөн нугалбараас, тухайн үед Лувсаншуну Торгуудад гоонь бие гозон толгой, цэрэггүй, бусдын хашаандахь золбин нохой янзтай өрөвдөлтэй дүр төдий байсныг харж болно.

Гэвч Найралт төв хаан цөхөрсөнгүй, 1731 онд Бандийн элчийн бүлгийг дахин Торгууд руу илгээжээ. Энэ бүлгийн “гол зорилго нь Торгуудын зэвсгийн хүчийг Зүүнгарын эсрэг болгохын зэрэгцээ тухайн үед Торгуудад амьдарч байсан улсын тайж Галданцэрэний дүүг ятган хятадын хаанд дагаар оруулах”⁴⁹ байв. Чин улс, Орос улсад Туушигийн элчийн бүлгийг хүлээн авсанд талархахын зэрэгцээ шинэ элчийн бүлгийг сайнаар нийлүүлэхийг хүсээд, арван мянган юаний үнэтэй торго, хөвөн нэхмэл зэрэг эд барааг хүргүүлжээ. Харин Орос, Торгууд Чин улстай ойр явалдаж байгаад санаа зовсон учир ашиг сонирхлоор нь сүрдүүлэн элчийг Торгуудад очуулахыг зөвшөөрсөнгүй. 1733 оны 1-р сард Оросын эрх баригчид Чин улсын элчид Лувсаншуну хэдийн нас барсаныг мэдэгдсэн⁵⁰ учир Бандийн

⁴⁹ Николай Бантыш Каменский. *Орос Хятад хоёр улсын гадаад харилцааны сурвалжийн эмхэтгэл*, 1982, Тал-215.

⁵⁰ Өмнө дурдсан Цай Жия Игийн зохиолд, Шуну 1741 онд амьд байсны зэрэгцээ Хасагтай хамтран Галданцэрэнтэй дайтсан хэмээн үзэв. Үнэндээ, Шуну дутаан явсны дараа Зүүнгарыг халдаар ирнэ гэсэн цуурхал ерөөс тасраагүй. Тухайлбал, 1729 оны 10-р сард Хоргос орчмоос дутаан Үрэмчид ирсэн хотон Хардбард хэлэхдээ: “Лувсаншуну хасаг руу дутаан очоод, хасагийн Абурайх ханы охиныг эхнэр болгов, одоо Лувсаншуну хасагийн цэрэг морийг дагуулан Илийн газрыг дээрэмдэж, Галданцэрэн Цэрэндондовын удирдсан цэргийг Чүй гол, Талас гол хиллэх газарт илгээн, харилцан тулалдав. Хасагийн цэрэг морь хүчирхэг учир Цэрэндондов дайсныг тулж чадсангүй...” (Найралт төвийн хятад улаан цохолборт айлтгалын бичгийн эмхэтгэл. 18-р боть. Тал-892.); Буриад Баханбуу, 1730 оны 1-р сард, Галданцэрэн гурван мянган цэргийг Шунугийн ирэх замыг тосон сахиулав” (Найралт төвийн хятад улаан цохолборт айлтгалын бичгийн эмхэтгэл. 18-р боть. Тал -165.); 1731 оны 5-р сард Зүүнгарын хүн Обаш Яркендад ирээд хэлэхдээ: “Галданцэрэний дүү Шуну баатар хасагт буй, их цэрэг удирдан түүний ах Галданцэрэнийг довтлон цохихыг хүснэ. Бас Галданцэрэн торгууд болон их Богд эзэн хэдийн холбоолдсоныг сонсоод, айж хасагийн зүг очин цэрэг малыг ихэд бэлтгэв” (Чин улсын Шинжааны манж айлтгалын эмхэтгэл (нэг), 2012. Тал 50-51.); Зүүнгараас оргосон хотон Милшөн 1732 оны 3-р сар, Лувсаншуну “тэдний (зүүнгарын тайж Сэвдэн) их бага гурван түмэн хүн малыг дээрэмдээд яав” (Найралт төвийн хятад улаан цохолборт айлтгалын бичгийн эмхэтгэл. 18-р боть. Тал -813.) Мантайгийн нугалбарын агуулгаас, Шуну Торгуудад очсоны дараа Зүүнгарыг цэргийн хүчээр сүрдүүлээгүй, Торгуудаас дэмжлэг олоогүй, Зүүнгарыг дайлсан зэрэг нь мянга нэгэн шөнийн үлгэр болох нь харагдана. 1731 оны хавар хүртэл Шуну Хасагт байж Зүүнгарыг довтлохыг хүссэн хэмээх нь хамгийн эрээ зээргүй боловч, энэ яг Мантай Торгуудад Шунутай хамт байсан үе. Эдгээр цуурхалыг Торгууд хүн Зүүнгарт хүнд байдлыг үүсгэхийн тулд, Хасаг хүн Зүүнгарыг сүрдүүлэхийн тулд, Зүүнгарын хүн Чингийн цэргийг гүн оруулахын тулд тархаасан байж болно. Цай Жиа Игийн ашигласан орос сурвалжид, 1741 онд “нэг Галданцэрэнгээр ах болгосон зүүнгарын хүн жанжин” жиржис (орос сурвалжид хасагийг зааж байна) хүний их цэргийг дагуулан зүүнгарын эдгээр оршин суугчдын бут зохив; мөн хасагаас дутаан ирсэн хүн хэлэхдээ, Шуну торгуудад зургаан жил амьдарсаны дараа хасаг руу очиж, 1741 онд “цэрэг удирдан Зүүнгарыг цохив” (Цай Жиа И. *Лувсаншунугийн нэг насны үйл хэргийг эмхэтгэн шинжлэх нь*. “Баруун монгол өгүүлллийн тавцан”. 2012 оны 2-р хугацаа, Тал-9.) гэсэн нь тухайн үед хасаг хүн Шунугийн нэрийг ашиглан зүүнгарыг довтлох гэсэн тайлбар төдий.

элчийн бүлэг Оросын хилийн хот Иркутскт цуцалтгүй хүлээсний дараа 1733 оны намар амжилтгүйгээр буцан иржээ⁵¹.

4. Торгуудын уран зохиолын баатар

Шуну Зүүнгарын эсрэг Хасагтай хамтарсан, Зүүнгарын хунтайжийг хөнөөх хуйвалдаанд оролцсон учир Зүүнгарын дайсан болсон нь түүхэн үнэн. Гэвч, Торгууд, Зүүнгарын эсрэг тэсрэг улс төрийн нөхцөл байдлын доор Шуну Торгуудын ардад гүнээр сайшаагдан, Зүүнгарт эсрэг баатрын дүрээр үзэгдэж, түүний хэрэг явдал Торгууд ардын дунд өргөн түгэж, аажмаар Торгууд хүн бүхний мэдэх уран зохиолын баатар болжээ.

Шунугийн явдал нь “Сэтэржавын тууж” болон ардын дуу “Нарийн говийн зээрд”-ээр дамжин түгжээ⁵². “Сэтэржавын тууж” нь XVIII зуунаас амаар дамжигдсан бөгөөд эдүгээ хоёр бичвэрийг эмхэтгэн гаргажээ. Нэг нь Оролайгийн эмхэлсэн бичвэр⁵³, нөгөө нь Пүрвэй ярьж, Бадмара эмхэлсэн найраг⁵⁴ болно. Хоёр эмхэтгэлийн агуулгын зөрүү их, түүхэн явдал нь адилгүй. Оролайгийн эмхэтгэлд: 75 настай Зүүнгарын хунтайж Торгууд хаанд 15 настай Сэтэржав нэртэй үзэсгэлэнт эмэгтэй байгааг сонсоод, дотны сайд Көмөшийг Торгууд рүү илгээн түүнийг богтлон, Көмөш энэхүү ургийн явдлыг бүтээв. Сэтэржав Зүүнгарын тайжтай урагласан хоёрдугаар жилд, нэг хүү төрүүлсэнийг, Шунай гэнэ. Шунай 10 настай байсан тэр жил, торгууд хаан Янмэн нэртэй мэргэн сайдыг, бичиг цэрэгт мэргэшсэн долоон баатартай хамт илгээн, Зүүнгар нутгаа эргэн очуулсан байна. Хунтайжийн дайллаган дээр хоёр талын сайдууд ухаан зоригоор тэмцэж, зүүнгарын хүн нүүрэн дээр ялагдав. Хунтайж тэгээд муу санаа үүсгэн долоон баатарыг алахаар бэлтгэв. Сэтэржав эхнэр Янмэнд зүүнгарын хуйвалдааныг

⁵¹ Николай Бантыш Каменский. *Орос Хятад хоёр улсын гадаад харилцааны сурвалжийн эмхэтгэл*, 1982. 214-235.

⁵² Лувсаншунугийн тухай уран зохиолын бүтээл *Сэвэржавын тууж, Нарийн говийн зээрд* –ийн уран зохиолын хүрэн дэх судалгаа их, гэвч түүний уран зохиолын бүтээлийн төрөл, уран зохиолын илэрхийлсэн арга зэрэг асуудлуудыг олонтоо хөнджээ, уг өгүүллийн сэдэвтэй холбоогүй учир энд ярилцахгүй. Лувсаншунугийн тухай бүтээлийн агуулга, түүхэн хамаарлын судалгааг Таяагийн *Ойрад монголын түүхэн дуу, Нарийн говийн зээрд-ийн тухай*” (Таяа, *Ойрад монгол үндэстний соёл судлал*. (《卫拉特蒙古族文化研究》) Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2006, Тал 269-285.) өгүүллээс дурдаж болно. Зохиогч түүхэн дуу өргөн түгсэн шалтгааныг гурван талаар шинжилжээ. Нэгдүгээрт, Лувсаншуну ардуудын хүндэтгэлийг хүлээсэн Зүүнгарын толгойлогч учраас; хоёрдугаарт, Зүүнгарын ард Галданцэрэнийг эсэргүүцэн, түүнийг хойд эхээ хүнлэг бусаар хөнөөснийг таашаагагүйн үр дүн учраас; гуравдугаарт, Лувсаншуну баатар байгаад, ардуудын хүндэтгэлийг олон магтан дуулагдсан учир гэжээ. Зохиогч Лувсаншунуг хилсээр хэлмэгдсэн эмгэнэлт баатар гэж үзжээ.

⁵³ “Хан тэнгэр”, сэтгүүл, 1981, 4-р хугацаа.

⁵⁴ “启明星” сэтгүүл, 1996, 2-р хугацаа.

сэмээр мэдэгдэжээ. Янмэн шулмасыг агнана хэмээн долоон баатраа удирдан дутаан гараад, торгууддаа аюулгүй буцан иржээ. Хунтайж Сэтэржав нууцыг задруулсныг мэдсэний дараа баруун хөхний тэнд нь хутгалж түүнийг алав, бас түүнээс төрсөн хүүхэд Шунай эхийнхээ өшөөг авахаас айн, түүний мөрийг гэмтээсэнд тэр эрэмдэг болжээ. Шунай хожим Зүүнгараас дутаан ирээд нагацын гэр Торгуудад хамгаалан суув.

Пүрвэйгийн шүлгийн агуулга нь: Зүүнгарын тайж өтөл насандаа торгууд хаан 17, 18 настай үзэсгэлэнт охинтойг сонсоод, хөгшин сайд Көмөшийг илгээн, ургийн явдлыг хэлэлцэв. Сэтэржав аргагүйн эрхэнд хайрт хүн Ёмэнээс салан хөгшин хунтайжтай ураглаж, нэгэн хүү төрүүлэв. Лам хүүд Шунай хэмээх нэр өгчээ. Хөгшин хунтайж бага Шунай маш хайртай учир ахмад хүү Галданцэрэн дүү Шунайг занаж эхлэв. Торгууд хан Ёмэн тэргүүтэй долоон сайдыг зээ хүүгээ эргүүлэхээр илгээсэнд, хунтайж болон эхнэр нь улсын зочны дүрмээр дайджээ. Энэ үед хунтайжид өвчин тохиолдож, эмчилгээ төгөлдөр болсонгүй удалгүй нас барав. Тэгээд Торгуудын элч хунтайжийг хөнөөсөн гэдэг цуурхал тархаж эхэлснээр, Галданцэрэн элчийг баривчлахаар бэлтгэсэн байна. Сэтэржав мэдсэний дараа нууцаар элч нарт мэдээг дуулган, тэднийг Зүүнгараас дутаахад тусалжээ. Шунай бас Зүүнгараас дутаан гарч нагац ааваа түшив. Эцэст нь Галданцэрэн Сэтэржавыг баривчилж, түүнийг баруун хөхийг хатган, түүний таван хүүг хамтад нь алав.

Үүнээс гадна Шунутай холбоотой өөр нэгэн ардын дуу бол *“Нарийн говийн зээрд”* бөгөөд нэлээд өргөн дэлгэрчээ. Энэ дууны үг зарим газарт их, зарим газарт бага боловч, агуулга нь үндсэндээ адил, бүгд Шунуг сайшаан магтан дуулжээ. Хоёр бадаг дууны үг маш сонгодог, түүний гол санаа нь:

Нарийн говийн зээрд
Наараан халиаж цэрэвнээ
Насан балчир Шунай нь
Нагацаа тэмцээд цэрэвнээ
 Гунан шарга морин
 Гуя талаа цамшина
 Гулзын төрсөн Шунай нь
 Нагацаа тэмцээд цэрэвнээ
Хуны хүзүүн гаанстай
Хурц хөх тамхитай
Хурц залуу Шунайг

Хураасан цэргээрээ морьдож ядлаа. Дуунд Шунуг сүр жавхлантайгаар дүрслэн, Зүүнгарын цэрэг ганцаар Шунуг нэхэж чадаагүй хэмээн ёжилжээ.

Тэгвэл, Зүүнгарын урвасан хулгай юунд Торгуудын баатар болов? тэр яагаад Торгуудын удирдагчдын дэмжлэгийг хүртэв, яагаад тэндхийн ардуудад сайшаагдав? Тэр зөвхөн Аюук ханы зээ хүү байсан учраас уу? Мэдээж үгүй. Энэ хэрэг Зүүнгар болон Торгууд ойрад хоёр хаант улсын зөрчил тэмцэлтэй холбоотой. XVII зууны 20 оны сүүлээр Торгуудууд Зүүнгарын бүс нутгаас Волга (Ижил) мөрний сав газрын тал нутаг рүү нүүн, XVII зууны 60 он хүртэл, түүний удирдагч Хоо Өрлөг, Шүхэр дайчин, Пунцаг гурвын ноёрхол доор Торгууд Волга мөрний сав газарт хаант улс байгуулсны зэрэгцээ хүчирхэгжин хөгжив. 1670 онд Пунцагийн хүү Аюук хаан ширээнд сууж, түүний суусан 54 жилийн (1670-1724) хугацаанд Торгууд хаант улс хөгжлийн шат руу оржээ.

Аюук сууринд суусны дараа эхлээд хошуудын Абулай тайжийг бут цохиод өөрийн авга дүү Дугартай зөрчилдөн, Волга мөрний бүс нутгийн бүхий л ойрад ардыг өөрийн захиргаанд оруулжээ. Үргэлжлүүлэн цэрэг хөдөлгөн Ясу, Керим, Шава, Калкарын бек нарыг довтлон, Торгууд хаант улсын хоёр тал Ази болон Кавказын тал нутгийн исламын шүтлэгтэн дунд давуу талыг олж авчээ. Аюук бас түрэг болон шаватай харилцаагаа сайжруулав. Шүхэрт дайчнаас нааш Торгууд Чин улстай хамгаалах харилцаатай, Төвөдийн Далай ламтай найрсаг харилцаатай байх бодлогыг баримталжээ. 1690 онд Далай ламаас V (үнэндээ Див) “Шүхэр хан” цол хүртэв. Зүүнгартай худ ураг барилдан охин Сэтэржавыг Цэвээнравданы эхнэр болгон өгчээ. Гэвч Торгуудын уг нутаг бол Зүүнгарын бүс нутаг, Зүүнгарын газар Торгууд болон Чин улсын дунд байсан учир Цэвээнравдан далдуур Торгуудаас эмээж, ялангуяа Торгууд болон Чин улсын харилцааг сэжиглэж байжээ.

1701 онд Торгууд-Зүүнгарын хооронд “Санжжавын хэрэг” үүсэв. “Чин улсын магад хууль”-нд тэмдэглэхдээ: *“тэр үед Цэвээнравдан хүч дорой бага байж, ихэд дуулгавартай байв. Тэр дараа нь түүний хадам аав торгуудын Аюук хан болон түүний хүү Санжжавыг хөндийрүүлэн, Санжжав түм гаруй өрхийг дагуулан, тэрний суусан газар ирсэнд, булаан өөртөө оруулав. Үүнээс ёсыг дагахгүй, эрээ цээргүй дураар явав”*⁵⁵ хэмээв. Санжжавыг мөн Санжав гэнэ, Аюук ханы хөвгүүдийн нэг. Энэ хэргийн тухай тод үсгийн сурвалж “Торгууд хаадын түүх”-д тэмдэглэхдээ, *“төмөр могой жил (1701) Аюукын хүү Чагдаржав түүний дүү Гунжавыг гэнэдүүлэн цохиж, тэгээд торгуудын дотоод самуун үүсэв, Чагдаржав*

⁵⁵ Чингийн Шизунгийн магад хууль. Боть 78. Найралт төвийн долоодугаар оны хоёр сарын харагчин могой өдөр.

дүүгийнхээ хэсэг албатыг дагуулан Улаар голыг гатлан, голын зүүн хөвөөнд суув. Энэ үед, Санжав Чагдаржавыг даган 15000 өрхийн ардыг удирдан зүүнгарыг зорив, Цэвээнравдан тэдний ардыг тэтгэн өөрийн албат болгоод зарлигаар Санжавыг гэрт нь буцаав”⁵⁶. Гаваншаравын “Дөрвөн ойрадын түүх”-д, Цэвээнравдан Санжавын ардыг эзлэн авав “модон бич (1704) жилийн нэг сарын 12-ны өдөр Санжавыг баривчлан түүний нэг түм таван мянган өрхийн улсын авав”⁵⁷ гэжээ. 1723 оны 8-р сарын 19-ны өдөр зүүнгарын Санж зайсан Оросын их бууны цэргийн ахмад И.Униковскийд ярихдаа: “өнгөрсөн жил, Аюукын хүү Санжав өөрийн эцгээс урван, цэргээ удирдан манай энд ирэв, муу явдал хийхийг хүсэв, тэр үед бид түүний ардыг хураан, түүнийг эцгийн газарт буцаав” гэжээ. Униковский мөн тэмдэглэхдээ, “үүнээс 25 жилийн өмнө, эсвэл 1700 оны орчим Аюук ханы хүү Санжав эцэг Аюукаас салж, Хасагийн жүз болон Башинжирын хоорондох тал нутгийг өнгөрөн, Эрчис голын Ямаш усул орчим суурьшив, тэндээс тайжийн улс руу мурийн, Эмин голд нутаглаад, тэнд өвлийг өнгөрөөв. Санжав 15000 хүнийг авч ирэв, бүх хүний тоо гурван түм эсвэл түүнээс олон” хэмээсэн байдаг. Цэвээнравдан Санжавын төрсөн эгч (эсвэл дүү Сэтэржав)-тэй гэрлэсэн учир хүн илгээж Санжавыг түүний тэнд очуулахыг хүсчээ. Санжав очилгүй, элч илгээн, энэ элчийг төвөдийн Далай ламын тэнд очуулахыг Цэвээнравдангаас хүссэн байна. Зүүнгарын хүний яриаг үндэслэвэл, энэ элчийн биенээс Санжавын Далай ламд илгээсэн захидлыг олсонд, “тэр санааг ашиглан Далай ламаас түүний хунтайжийг алах санааг зөвшөөрөхийг хүссэн мэт”. Зүүнгарын хүн элчийг нууцаар шоронгоос гаргаад, Цэвээнравдан архи болон морь хонийг Санжавыг буудалсан газарт хүргэн, тэднийг дайлах дүр эсгэн, завшааныг хүлээн Санжав болон түүний албатыг бариад, Санжав болон түүний эхнэр хүүхэд дагалдах 10 хүнийг Аюукын газарт буцаан, түүний ардыг зүүнгарын улсуудад хуваан өгчээ⁵⁸. Санжавын дагуулсан ардын Зүүнгарыг түших уг санаа ямарыг зүйл зүйлээр хэлдэг боловч ямартай ч Цэвээнравдан Санжавыг баривчлан хүргээд, түүний 15000 өрхийн ардыг (эсвэл 10000) эзлэн авч, Зүүнгарын отгуудад хуваан өгсөн нь, түүхэн хэрэг. Жишээ нь, Зүүнгараас олзлогдсон Манж нь өчихдөө, тэрбээр Санжавын хуучин харьяат, тэр жил Цэвээнравдан тэднийг зүүнгарын отгуудад тархаан өгсөн⁵⁹ хэмээв. Зүүнгарт саатуулагдсан энэ мэт олон торгууд

⁵⁶ Зохигч тодорхойгүй. *Торгууд хаадын тууж, (тод бичиг)* //Бадаа, Алтаншаа, Эрдэнэ эмхэтгэн тайлбарлав, Ойрад соёлын дээж, Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1992. Тал 347.

⁵⁷ Гаваншарав, *Дөрвөн ойрадын түүх, (тод бичиг)* //Бадаа, Алтаншаа, Эрдэнэ эмхэтгэн тайлбарлав, Ойрад соёлын дээж, Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1992, Тал 256.

⁵⁸ Униковский, И. *XVIII зуунд их бууны цэргийн ахмад Шинжаанд үзэж сонссон тэмдэглэл*. Орчуулсан Сун Сиши. Хармөрний боловсролын хэвлэлийн хороо, 1999, Тал-127, 202-203.

⁵⁹ Баривчлагдсан Манж хэлэхдээ “*Би торгуудын хүн, торгуудын Аюук ханы хүү Санжавын хүн*.”

ардын хэрэг Аюук ханы хилэнг хөдөлж, хоёр талын харилцаа илт муудав. Дараа жил нь Цэвээнравдан Аюук ханы Чин улс руу илгээсэн элчийн бүлгийг довтлон, Зүүнгараар дайран өнгөрөх Торгууд, Чин улс, Төвөдийн харилцааг тасалжээ. Иймд энэ үед Төвөдөд байсан Аюукын ач хүү Аравжур буцах аргагүй болов. 1703 онд, Аравжур Төвөдөөс Бээжинд очин Энх-Амгалан хаантай уулзсанаар Чин улс Сэртэн газарт тохинуулан суулгажээ. Энэ хэрэг нь Торгууд-Чин улсын харилцааг улам дотно болгосон байна. 1709 онд Аюук хан Самтанаар элчийн бүлгийн ахлуулан Чин улс руу илгээжээ. 1714 онд Энх-Амгалан хаан Түлишэний элчийн бүлгийг илгээн Волга мөрөнд очуулснаар хоёр талын хооронд Зүүнгарыг аргалах болон Торгуудыг зүүнш буцаах яриа бараг энэ үеэс эхэлжээ.

Торгууд-Зүүнгарын дээрх харилцааг үндэслэвэл 1723 оноос хоёр талын хооронд худ ураг элч түшмэдээр дамжуулан харилцах харилцаанд нэгэн шинэ хуйвалдаан эхэлсэн магадлал өндөр. Өгүүлсэнээс үзвэл, Цэвээнравдан ураг барилдахыг санал дэвшүүлэн, маш хурданаар Торгуудууд халуун дотноор хүлээн авч, нэг охиныг сүй тавин торгуудад хүргэх хэлэлцээр нь дөрвөн охины сүйн хэрэг болон өөрчлөгдөж, Цэвээнравдан шинэ бэрийг 8000 хүнээр хамгаалуулан хүргэхээ амлав. Хэрэг явдлын өрнөл маш халуун дотно, магад эхэндээ хоёр тал эдгээр хуримын явдлыг ашиглахын хүсч зорилгодоо хүрэхийн тулд нууцалсан нь, тэр жил Цэвээнравдан биеэр хүргэхээр шалтаглан Лазан ханыг мөхөөсөнтэй адил. Гэвч Шуну зэрэг хүний оролцоотойгоор, эцэстээ торгууд хүн амжилтанд хүрч Цэвээнравданыг устгав.

Гэвч, Шунутай хамаарал бүхий үлгэр болон ардын дуу тэртээ Волга мөрний тал нутгийн Халимагаас Монгол улсын баруун аймгийн дөрвөдөд хүртэл, Хятадын Шинжаанаас Алашаагийн ойрадуудад хүртэл өргөн тархжээ. Үлгэр болон ардын дуу нь хамгийн анх Волга мөрний сав газрын Торгуудад бий болжээ. Үлгэр нь түүхэн явдлын үнэн байдалд тулгуурлах ёстой боловч үлгэр болон түүхэн явдлын зөрүү маш их байна. Үлгэр нь Шунуг сайшааж, Зүүнгарын хунтайж эцэг хүүг дайран, Шунуг нэгэн эмгэнэлт баатар болгон дүрсэлсэн нь уг хэргийн талаарх тухайн үеийн Торгуудын байр суурийг тусгажээ. Зүүнгар дайсны уран зохиолыг бүтээснээр Шуну энэхүү Зүүнгарын урвасан хулгай боловч, Торгуудын томоохон баатар болов. Тэгвэл Шунугийн энэ дүрийг хожим бүх ойрад, тэр ч байтугай

Тэр жил түүний эцэгтэй зөрөлдөөн байж, нэг түмэн хүнийг удирдан Цэвээнравданыг түшихээр ирэв, Цэвээнравдан манай тайж Санжжавыг бариад, торгуудын газарт буцаан хүргэв. Манай нэг түмэн торгуудыг түүний доорх аймгийн зайсан нарт хуваан өгөв, миний эцэг эх, миний бие болон дүүг Туубиж зайсаны аймагт өгөв” гэсэн байдаг. (Энх-Амгалангийн үеийн манж улаан цохолборт айлтгалын бичгийн бүрэн орчуулга. Хятадын Нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо, 1996. Тал-1013. // 《康熙朝满文朱批奏折全译》，中国社会科学出版社。)

бүх монголчууд яагаад хүлээн авсан вэ? XVIII зууны дунд үе хүрч Зүүнгар улс мөхсөнөөр Торгуудын дайсан түүхийн тавцнаас замхарч Торгуудууд зүүнш уг нутагтаа буцав. Шунугийн тухай үлгэр болон ардын дуу Зүүнгарын газарт тээгдэн ирж, бусад ойрадууд болон монголын бүх хэсгүүдэд уламжлагдсан байна. Эдгээр бүтээл бий болох хооронд дайсагнагч улс нь мөхөж, тэр жилийн өшөө хорсолоор дүүрсэн сэтгэл нь замхарч, хүмүүсийн дурсамжинд нэгэн баатрын тухай магтаал дуу төдийхөн хоцорчээ. Зарим өвөрмөц түүхэн явдал нь ардын уран зохиолд бүтээл болон хоногшиж, төр халагдах эсвэл өнө удаан цагийн эрхээр анхы онцгой утгаа алдаж, хойч үеийнхэн дунд бүх нийтэд үнэ цэнэтэй өнө мөнхийн амь насыг олж авдаг. Шуну Торгуудын баатараас хувьсан одоогийн бүх Монголын уран зохиолын баатар болсон нь ийм учиртай.

Харамсалтай нь Шунутай холбоотой уран зохиолын бүтээлтэй адил нөлөөг одоогийн судлаачид хүртэн, олонх Ойрадын уран зохиол түүх судалдаг хүмүүс нэг мэдэхэд Шунугийн талд зогсож байна. Үнэндээ Шунуг сайшаан дэмжих ямар ч тал байхгүй, тэр зөвхөн Зүүнгарын дээд эрх мэдлийн тэмцэлд ялагдсан дайсан, түүний эх болон ах дүүсийн эмгэнэл нь Шунугийн үүсгэсэн зүйл. Хэрэв Шуну нэгэн түүхэн хүнийг судлах ач холбогдолыг ярьвал нэгэн нэрд гараагүй залуу Чин улс болон Евро азийн эх газрын хоёр Ойрад хаант улс энэ том тайзан дээр, тухайн үеийн олон улсын улс төрийн ашиг сонирхолын тоглолтон дээр гарч ирсэн нэгэн жүжгийн онцлог дүр юм. Уг хүнийг судлах нь ямар нэгэн үнэ цэнэгүй гэж хэлж болох ч түүний бие дээр гарч ирсэн түүхэн явдал нь XVIII зууны Зүүнгарын түүх, Зүүнгар-Торгуудын харилцаа хийгээд Чин улсын Евро азийн тал нутгийн нүүдэлчин улсуудад чиглүүлсэн баруун умардыг байлдах бодлогыг судлахад харилцан чухал ач холбогдолтой.

Abstract

Small Figure, Big Arena, and Crucial Character: Lobsangshunu, Oyirad Khanates, and the Qing Dynasty in Eighteenth-Century Eurasia

Lobsangshunu was a son of Zunghar Khan Tsewang Arabtan and Seterjab, who was a daughter of Torghut Khan Ayusi. Due to the violent internal struggle within in Zunghar Khanate, Lobsangshunu escaped to Torghut and Seterjab's children were oppressed by Tsewang Arabtan's eldest son named Galden Tsering. Due to the complicated historical background, Lobsangshunu took refuge in Torghut Khanate and became a thorn in Zunghars' side. Meanwhile, the Qing dynasty paid close attention to Lobsangshunu. The Yongzheng Emperor sent envoys to Torghut and hoped to bring Lobsangshunu

back to Beijing in order to utilize him against Galden Tsering. By utilizing records related to Lobsangshunu in multilingual archives, this article discusses the diplomatic relationships and military strategies between Torghut, Zunghar, and the Qing dynasty.

Хятад хэлнээс орчуулсан: Л.Энхсаруул

Ном зүй

1. Badai, Jinfeng, Eerdeni. *Weilate shiji* (The Traces of Oirats), Urumchi: Xinjiang renmin chubanshe, 1992.
2. Cai Jiayi. “Luobuzang shunushengping shiji jitan”(The Materials for the Biography of Lobsang Shunu), *The Forum of Western Mongols*, 2 (2012) .
3. Liu Jin. “Qingdai Yongzhengchao de xibei zhengce yanjiu” (The Northwestern Policies of the Emperor Yongzheng), Beijing: Central University for Nationalities, Ph. D thesis, 2013.
4. Ma Ruheng & Ma Dazheng. *Shilun”Yongzheng yu Tuerhute han chishu”yu Mantai shituan de chushi* (Concerning Yonzheng’s”Decree to Torgouts”and the Circumstances of Matai’s Embassy), *Minzu Yanjiu*, 1 (1988) .
5. P. S. Palasi. *Neilu yazhou Elute lishi ziliao* (Merkwürdigkeiten der Morduanen, Kasaken, Kalmücken, Kirgisen, Baschkiren etc. : Nebst andern dahin gehörigen Nachrichten und Kupfern: Ein Auszug aus Pallas Reisen. Band 1 - 3 (Frankfurt [Frankfurt a. M.]; Leipzig: S. n., 1773) ; translated by Zhao Jiandong and Liu Yingsheng, Kunming: Yunnan renmin chubanshe, 2002.
6. Ruo Songkuan. “Cewang alabutan de jueqi” (The Rise of Tsewang Arabtan) in *History and Religion of Mongols under the Qing Dynasty*, Harbin: Helongjiang jiaoyu, 1994.
7. Taya. *Guanyu Weilate Menggu Lishi Gequ”Nalin Gebi de zaohongma”* (Concerning Oirat Mongol epic song *Crimson Horse of Narin Gobi*), in *Studies in Culture of Oirat Mongols*, Huhhot: Nei menggu renmin chuanshe, 2006.
8. Wang Xi. “Gaerdanceling tongzhi shiqi (1727—1740) Zhungaer yu Qingchao de zhanzheng yu yihe yanjiu” (The War and Peace in the Qing-Dzhungar relations during the time of Galdan Tsering (1727—1740)), Beijing: Renmin University of China, Ph. D thesis, 2015.
9. Wenkefusiji. *Shiba shiji eguo paobing dawei xinjiang jianwenlu* (The Records of Xinjiang as seen by the Russian Captain of Artillery, translated into Chinese with notes by Song Sixi, Harbin: Helongjiang jiaoyu chubanshe, 1999.
10. Zilatejin. *Zhungaer hanguo shi* (The History of Dzhungar Khanate, Translated into Chinese as: I. Ya. Zlatkin, translated with notes by Ma Manli), Lanzhou: Lanzhou daxue chubanshe, 2013.
11. Zhao Weibing. *Hasake yu Zhungaer zhengzhi guanxi shi yanjiu 1680 - 1745* (The Historical Connections between Kazakhs and Dzhungars: 1680 - 1745), Urumchi: Xinjiang Normal University M. A. thesis, 2010.